



НЭР ТӨР, ШУДАРГА ЁСЫГ ХҮН БҮРТ

АГУУЛГА

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 60 жилийн ойн хүрээнд Хүний эрх, эрх чөлөөг хангах талаар хийсэн ажлын мэдээлэл

Улсын Дээд Шүүх	2
Цагдаагийн Ерөнхий Газар	4
Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар	9

Нийтлэл

Я.Ижилмөрөн	
Хүүхдийн эрх - Судалгаан дээр үндэслэсэн арга зүй	14
Б.Батцэцэг	
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай	
НҮБ-ын конвенцийг соёрхон батлах хэрэгцээ шаардлага	19
Т.Ихтамир	
Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл	31
Ч.Отгончулуун	
Олон нийтийн үймээн самууны үед анхаарах зарим асуудлууд	36
Б.Долгион	
Цагаач ажилчдын эрх	42
М.Цолмон	
Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	48
Ч.Алтангэрэл	
Боловсрол дахь эрхэд суурилсан үзэл баримтлалын хүрээ	54

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭЭС ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ
ХАНГАХ ТАЛААР ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙСЭН
АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Улсын Дээд Шүүх нь хүний эрх, эрх чөлөөг хангах, эрх нь зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг нь хамгаалах, хуулийг нэг мөр зөв ойлгох, хэрэглэх талаар хуулийн тайлбар 13-ыг батлан гаргасан.

Эрүүгийн хэргийн танхим

-Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт хэрэглэх тухай

-Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай

-Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгө булаах” гэмт хэргийг 147 зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар,

-Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах, санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэх талаар,

-Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай,

-Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай,

Иргэний хэргийн танхим

-Монгол улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай,

-Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

-Монгол Улсын Сонгуулийн Төв байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай,

-Орон сууц болон орон сууц хувьчлах тухай хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай,

-Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай,

Захиргааны хэргийн танхим

-Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай,

-Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай тогтоолуудыг батлан гаргасан.

“Хууль зүйн хүртээмж ба Хүний эрх” төслөөс “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” тогтоол гаргасантай холбогдуулан “Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж байгаа практик” сэдвээр улсын хэмжээнд нийт шүүгчдийн дунд судалгаа явуулсан.

Улсын Дээд Шүүхээс гаргасан хуулийн албан ёсны тайлбаруудыг шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллагын ажилтнууд, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад зориулан тогтоолын эмхтгэл болгон хэвлүүлж гаргаснаас гадна “Дээд шүүхийн мэдээлэл”, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдэд тогтмол хэвлүүлдэг. Мөн өөрийн вэб сайт болон Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тус тус байрлуулан олны хүртээл болгож байна.

2. Эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимууд хүний эрх, эрх чөлөөг хангах талаар дээрх хуулийн тайлбаруудаас гадна анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээс шийдвэрлэж буй шүүхийн практикийг судалж цаашид тухайн төрлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд гарч буй алдаа, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгох, хэрэглэх явдлыг хангах зорилгоор зөвлөмж боловсруулан гаргасан.

Эрүүгийн хэргийн танхим энэ оны эхний хагас жилийн байдлаар Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбогдсон зарим асуудлыг зохицуулах тухай журмыг Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран гаргаж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийг шүүхийн практикт зөв хэрэглэх талаар, ЭБШХ-ийн 99 дүгээр зүйлийн 99.2-т “байцаан шийтгэх ажиллагааны зардлыг төр хариуцна” гэж заасныг шүүхээс зөв хэрэглэх тухай, Иргэний хэргийн танхим Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэглэхэд анхаарах зарим асуудлын талаар Захиргааны хэргийн танхим Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зарим зүйл, заалтыг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай, Ашигт малтмалын тухай хуулийн зохицуулалтыг нэг мөр зөв ойлгох, хэрэглэх, шүүхийн практикт гарч байгаа алдаа зөрчлийг арилгах тухай зөвлөмжүүдийг тус тус гаргажээ.

3. Эрүүгийн хэргийн танхим нь Улсын Ерөнхий Прокурорын Газар, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо болон Хууль Зүй Дотоод Хэргийн Яамтай хамтран “Өмгөөлөгчдийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт уулзалт ярилцлага, Иргэний танхим аймаг, нийслэл, дүүргийн шүүхүүдийн шүүгч нарт “Бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг ба шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал” сэдэвт сургалт зохион байгуулж ажиллалаа.

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ
ХАНГАХ ТАЛААР 2008 ОНЫ ЭХНИЙ 7 САРД
ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Цагдаагийн байгууллага нь 2008 онд Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол шийдвэр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2008 онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд цагдаа, дотоодын цэргийн нийт байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн, үйл ажиллагааны стандартыг шинэчилж, албаны шуурхай байдлын түвшинг ахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлыг эрчимжүүлэх, сургалтыг чанаржуулж, алба хаагчдын мэдлэг, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, тэдний санал, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэхэд анхаарч ажилласан бөгөөд 2008 оны эхний 7 сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 49085 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсан нь 2007 оны мөн үеэс 11.9 хувиар өсч, гэмт хэргийн шинжтэй 4 гомдол, мэдээлэл тутмын 1-д эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан.

Улсын хэмжээнд 12188 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 3799 гэмт хэрэг бүртгэгдэн, 1116 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 29.4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4.2 пунктээр, нийслэлийн хэмжээнд 29.2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6.3 пунктээр өссөн статистик үзүүлэлт гарч байна.

Гэмт хэргийн улмаас 11618 иргэн хохирсны 30.7 хувь нь эмэгтэйчүүд, 5.8 хувь нь насанд хүрээгүй хүмүүс, 29.1 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс, 12.2 хувь нь хохирогчийн буруугаас гэмт халдлагад өртсөн байна. Гэмт хэргийн улмаас төр, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 31.0 тэрбум төгрөгийн хохирол учирсныг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад 541.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилж, 11.1 хувийг нөхөн төлүүлж ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд гэмт хэргийн улмаас 1041 хүн нас барж, 5003 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс нас барсан хүний тоо 5.5 хувиар буурчээ.

“Сахилга, дэг журам, ажлын хариуцлагыг сайжруулах тухай” Засгийн газрын 2007 оны 13 дугаар албан даалгавар, ЦЕГ-ын даргын тушаалаар “Нээлттэй өдөр”-ийн арга хэмжээг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд сар бүрийн 2 дахь 7 хоногийн Пүрэв гаригт зохион байгуулж дээрх арга хэмжээнд нийт 33872 иргэд хамрагдсан байна.

Арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 2290 санал, 2518 хүсэлт, 395 гомдол, 311 мэдээлэл хүлээн авч шийдвэрлэн хариу өгч ажиллав.

“Нээлттэй өдөр”-ийн арга хэмжээний үеэр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 32733 санамж, сэрэмжлүүлэг, тараах материалыг иргэдэд тарааж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 335 сурталчилгаа, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 26 онцлог саналыг хүлээн авч ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын вэб сайтаар иргэдээс өргөдөл, гомдол, мэдээллийн шинжтэй 39 цахим шууданг хүлээн авч, хариуг өглөө.

Түүнчлэн Замын цагдаагийн албаны чиглэлээр иргэдийг чирэгдүүлэхгүй шуурхай үйлчлэх, төрийн үйлчилгээг нэг цэгээс тосч үйлчлэх зорилгоор “Угтах үйлчилгээ”-г эхлүүлэн хуваарийн дагуу ахлах байцаагч, байцаагч нарыг ажиллуулж байна.

Хүний эрхийг зөрчсөн, иргэдийг чирэгдүүлсэн, албан тушаалдаа хайнга хандсан тухай цагдаагийн албан хаагчтай холбоотойгоор иргэд, байгууллагаас ирүүлсэн 142 өргөдөл, мэдээлэл, албан бичиг болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн 4 материалд албаны шалгалт явуулж Цагдаагийн Ерөнхий Газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж зөрчил гаргасан 40 албан хаагчид “Цагдаагийн байгууллагын тухай” хуульд зааснаар сахилгын шийтгэл оногдуулж, 9 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн Байцаах Албанд шилжүүлж, 3 албан хаагчид холбогдох асуудлыг Авлигатай Тэмцэх Газарт шалгуулахаар хүргүүлж шийдвэрлэсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 48 дугаар тогтоолын дагуу алба хаагдын үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг нь хариуцсан ажил, үүргийн чиглэлээр нь төрөлжүүлж, алба хаагч бүрийн мэдвэл зохих эрх зүйн жагсаалтыг гаргаж, цэгцлэх ажлыг зохион байгуулж байна.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2008 оны 93 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж 2008-2010 онд хэрэгжүүлэх “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах ажлыг эхлээд байна.

Цагдаагийн алба хаагчдыг зөрчлийн улмаас оноосон торгуулийн мөнгөний хувиар байгууллага алба хаагчийг урамшуулдаг, санхүүжүүлдэг, торгууль ногдуулах төлөвлөгөө, даалгавар өгдөг, түүгээр ажил дүгнэдэг асуудлыг таслан зогсоох талаар үүрэг чиглэл өгч биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Бүх шатны удирдах ажилтны хяналт, мэргэжлийн туслалцааг, алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэхэд чиглүүлж, аливаа шагнал урамшуулал, албан тушаалд дэвшүүлэхэд хүний эрхийг хангах талаар хэрхэн ажилласан, хүний эрхийн зөрчил, дутагдалгүй ажилласан байдлыг гол шалгуур болгон хэвшүүлэн ажиллалаа.

Хохирогч, сэжигтэн, яллагдагчийг өмгөөлөх эрхээр хангах, тэдэнд эрхээ эдэлж өмгөөлөгчөө сонгох боломжийг олгох талаар “Хууль зүйн товчоо” болон өмгөөлөх байгууллагатай хамтран ажиллаж, өмгөөлөгчдийн нэр хаяг, утас, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хамгаалсан хуулийн заалт бүхий мэдээ, мэдээллийн лавлагааг гарган хүлээх танхим, алба хаагчдын өрөө, тасалгаанд байрлуулан, “Цагдаагийн байгууллага нь иргэдэд үйлчлэх байгууллага байх ёстой” гэсэн зарчмыг баримтлан иргэдэд чирэгдэл учруулахгүй, хүнд сурталгүй, түргэн шуурхай, соёлч боловсон үйлчлэх зорилго тавьж ажиллаж байна.

Цагдаагийн зарим газар, хэлтсүүд, эрүүлжүүлэх, баривчлах байрны дотоод орчин нь иргэдийн эрх зөрчигдөх байдалд хүргэхээс урьдчилан сэргийлж, тохилог орчинг бүрдүүлэх зорилгоор засвар үйлчилгээний асуудлыг алба хаагчдын санал, санаачлага, байгууллагын нөөц бололцоонд түшиглэн хийж байна.

Нийслэлийн Цагдаагийн газрын Хүүхдийн халамж үйлчилгээний төвд 2008 оны эхний хагас жилд 531 хүүхэд хүлээн авсны дотор давтан ирсэн 350, шинээр ирсэн 130, төөрсөн 50, хаягдсан 1 хүүхэд байснаас 405 хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, “Дэлхийн зөн” Монгол дахь олон улсын байгууллагад 4, хүүхдийн хөдөлмөр сургалтын төвд 46, бусад төвд 50 хүүхдийг хүлээлгэн өгөв.

Мөрдөн байцаах газар хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд насанд хүрээгүй хүүхдийн байцаалтын өрөөг Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр Хүний эрх мэдээлэл төвтэй хамтран төсөл боловсруулан тохижуулж үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна.

Мөн хараагүй болон тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд Мөрдөн байцаах газрын 1 дүгээр давхарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байцаалтын өрөө тохижуулах төслийг боловсруулан ажиллаж байна.

Хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, алба хаагчийн сахилга, ёс зүйг чанд сахих, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эрүүдэн шүүхийн эсрэг олон улсын конвенци, хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг сэдвүүдээр алба хаагчдад Хүний Эрхийн Үндэсний Комисс, Сонгуулийн ерөнхий хороо бусад холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтарсан уулзалт, зөвлөгөөн, сургалтуудыг зохион байгуулав.

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2008 оны 3 сард зохион байгуулсан “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь” сэдэвт сургалтад Замын цагдаагийн газар, Хэрэг бүртгэх газар, Мөрдөн байцаах газар, дүүргийн цагдаагийн хэлтсүүдийн мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нийт 20 алба хаагчийг оролцуулсан нь үр дүнтэй ажил болсон гэж үзэж байна.

Түүнчлэн Хүний Эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан “Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт 10 хоногийн семинарт 1 албан хаагчийг, 2008 оны 6 сарын 25-нд болсон “Эрүү, шүүлттэй тэмцэх нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтад 15 алба хаагчийг, 6 сарын 26-нд зохион байгуулсан “Эрүү, шүүлтээс ангид байх Хүний эрх” сэдэвт онол, практикийн бага хуралд 5 алба хаагчийг тус тус оролцуулсан.

АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэл” хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Баянгол, Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт “Хэргийн газрын үзлэг” сэдэвт сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, энэхүү сургалтын агуулгын хүрээнд ажлын арга барил, туршлагыг судлуулан Цагдаагийн академийн сургалтанд ашиглуулах зорилгоор тус академийн багш нарыг ажиглагчаар, мөн Гадаад харилцааны яамнаас “Хүн худалдаалах” гэмт хэргийн талаар зохион байгуулсан сургалтанд Цагдаагийн академийн 1 багшийг тус тус оролцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт хүний эрхийн үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг нийт бие бүрэлдэхүүнд хүргүүлж сургалтын материал болгон ашиглаж байна.

2008-2009 оны хичээлийн жилд Цагдаагийн байгууллагын нийт бие бүрэлдэхүүнд

явагдах мэргэжлийн болон давтан сургалтын төлөвлөгөөнд “Хүний эрхийг хангах асуудал”, “Авилгын гэмт хэргийн ойлголт, төрөл, хэлбэр, урьдчилан сэргийлэх нь”, “Алба хаагчийн ёс зүйн асуудал” зэрэг сэдвүүдийг түлхүү оруулж сургалтыг зохион байгуулж байна.

Мөн Цагдаагийн байгууллагаас хүний эрхийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор алба хаагчдыг орон сууцны хөнгөлөлттэй зээлд үе шаттайгаар хамруулан орон сууцны хангамжийг сайжруулах, байгууллагын мэдлийн орон сууцны барилга барих талаар орон сууц, санхүүжилтийн корпорацитай 2008 онд хамтран ажиллах тухай гэрээ байгуулав.

Энэ гэрээнд Улаанбаатар хотод цагдаагийн нийт 120 алба хаагчийг орон сууцны урт хугацааны зээлд хамруулах, аймгийн төвүүдэд баригдаж байгаа орон сууцны барилгуудаас жилд 10 хүртэлх хувьд нь цагдаагийн алба хаагчдыг урт хугацааны зээлд хамруулан орон сууцжуулах, сумдад баригдаж байгаа орон сууцны барилгуудаас тус бүр 1 айлын орон сууцыг тухайн орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс худалдан авч байхаар тусгалаа.

Алба хаагчдын эрүүл мэндэд анхаарч, эмчийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн нэгдсэн судалгааг гарган тодорхой ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Хүний эрхийг хамгаалах, иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, иргэд, олон нийтэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой санал, зөвлөмжийг тогтмол өгч ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс цагдаагийн алба, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр Монголын үндэсний радиогийн “Монгол цагдаа” нэвтрүүлгийг 52, малхулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Буянт мал” нэвтрүүлгийг 52, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийн “Хурд” агентлагаар 8, “МОНЦАМЭ” агентлагаар 6, “Улаанбаатар FM-102.5” радиогоор 8, “Авто радио FM-96.3” радиогоор 20 удаа, “МҮОНТ”-ээр “Дуудлага” нэвтрүүлгийг 18 удаа бэлтгэн явуулж “TV-5”, “TV-8”, “TV-9”, “UBS”, “Eagle”, “C1”, “TM”, “STV” телевизүүдээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон цаг үеийн шинжтэй арга хэмжээнүүдийн талаар нийт 309 удаагийн ярилцлага, мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРААС ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ТАЛААР ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ


Монгол Улсын Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллага нь эрх зүйн шинэтгэл, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 2007 онд албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, албаны бэлэн байдлыг өндөржүүлэх, цагдан хорих байранд хоригдогсдын болон хорих ял эдэлж байгаа ялтнуудын эрхийг хуулийн хүрээнд хангах, орчин нөхцөлийг нь олон улсын жишигт ойртуулах, аж ахуй, үйлдвэрлэлийг сэргээх, албан хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулах, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийг өнөөгийн шаардлагын түвшинд хүргэх, гадаад харилцааг хөгжүүлэх зэрэг томоохон зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж ирлээ.


Ялтны байрны багтаамж, ахуй нөхцөлийг сайжруулах чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 188 дугаар тогтоол гарч Авдрант дахь онцгой дэглэмтэй хорих ангийн ял эдлэгсдийн байрны багтаамж ахуй нөхцөлийг сайжруулах зорилгоор Дархан-Уул, Булган аймаг дахь хорих ангиудад нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Цагдан хорих байранд хоригдогсдын эрхийг Олон Улсын стандартын дагуу хангах үүднээс Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Цагдан хорих төв”-ийн барилгыг шинээр эхлүүлэн барилгын ажлыг гүйцэтгэж байна.

Түүнчлэн 2006 онд Архангай, Баян-Өлгий, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ аймаг, Хөтөл дэх цагдан хорих байрыг шинэчлэн засаж тохижуулснаас гадна Булган аймагт 60 хүний багтаамжтай цагдан хорих байрыг барьж ашиглалтанд орууллаа.

Ганц худаг дахь Цагдан хорих ангид их засвар хийж, албаны конторын барилга шинээр барьж ашиглалтанд өгснөөс гадна насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч нарын сургалтын танхим болон өмгөөлөгчтэй уулзах байр зэргийг шинээр байгуулж тохижууллаа. Мөн Төв аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрны барилгын өргөтгөлийн болон засварын ажлыг хийсэн.





Дархан-Уул, Төв аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албадын цагдан хорих байруудыг засаж тохижуулахаас гадна төвийн халуун, хүйтэн ус, бохирын шугаманд холбож байна. Тус аймаг дахь хорих ангийг орчин үеийн жишигт нийцэхүйц хорих анги болгох зорилт тавин, зураг төслийг нь гаргаж, барилгын ажлыг эхлүүлээд байна.



Эмэгтэйчүүдийн хорих ангийг цэвэр бохир усны шугаманд холбосноос гадна шинээр 2 давхар конторын барилга, ялтны соёлын төвийг барьж ашиглалтад өгсөн. Хархорин, Хэнтий аймаг дахь хорих ангиуд ялтны байрыг төвийн цэвэр, бохир усны шугаманд холбох ажлыг хийгээд байна.

2006 онд Тахир соёот, Дарь Эх, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Хархорин, Дарьт, Ховд дахь хорих ангиуд ялтны амьдралын байрны нөхцлийг сайжруулан их засварын ажлыг хийж дуусгалаа.



Авдрант, Тоосго, Мөнгөнморьт, Тахир соёот дахь хорих ангиуд ялтны амьдралын байр, эмнэлэг, амралт, биеийн тамирын талбайг шинээр засаж тохижуулсан болно.

Ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр: Хорих ял эдлээд суллагдсаны дараа тухайн иргэнийг нийгэмшүүлэх, төлөвшүүлэх асуудалд анхаарч, зохих ажлуудыг зохион байгуулж байна.



ШШГЕГ-ын харьяа хорих ангиудаас суллагдан гарч буй хүмүүсийг тухайн орон нутгийн мэргэжлийн сургалтын төвөөр дамжуулан мэргэжилтэй болгох, хөдөлмөрийн биржүүдээр дамжуулан ажилд зуучлах зэрэг арга хэмжээг эрчимжүүлэн ажиллахын зэрэгцээ суллагдагсдыг оршин суух тухайн орон нутгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, ажил олгогч эздийн холбоо, төрийн

бус байгууллагуудтай холбох, тэдний иргэний баримт бичгийн бүрдүүлэлтэд туслах, зөвлөгөө өгөх, зуучлахад гол анхаарлаа хандуулан ажиллаж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд хөдөлмөрийн биржүүдэд 150 гаруй, төрийн бус, сайн дурын байгууллагад 40 гаруй, орон нутгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсүүдэд 30 гаруй, бусад төрийн захиргааны байгууллагад 90 гаруй хүнийг тус тус зуучлаад байна.

Мөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууллага, аймаг дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн харьяа хөдөлмөр зуучлалын албадуудаар дамжуулан ажлын байраар хангах, хорих ял эдлээд суллагдсан этгээд хаана очих, гэр бүл, амьдралын баталгаат орчны талаар судалгааг сум, хороо дүүргийн нийгмийн ажилтнууд гарган холбогч, зуучлагчийн үүрэг гүйцэтгэх ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Албан хаагчдын нийгмийн баталгаа: 2006-2009 онд Нийслэл Улаанбаатар хот болон төв, орон нутагт 463 айл өрхийг орон сууцтай болгох зорилт тавин орон сууц барих мөрийн хөтөлбөрийг гарган ажиллаж байгаагийн дүнд Улаанбаатарт 80, Хэнтий аймагт 12, Булган аймаг, Төв аймгийн Маантад нийт 8 айлын орон сууцыг тус тус шинээр барьж, Говьсүмбэр аймаг дахь хорих ангийн албан хаагчдын 30 айлын орон сууцанд их засварын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад өгсөн.

2006 онд Дорноговь, Өмнөговь аймгууд дахь Шийдвэр гүйцэтгэх албаны конторыг шинээр барьж, Багануур, Баянхонгор аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албадын конторын барилгад их засвар хийж, Сэлэнгэ аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны конторын гадна орчныг засаж тохижуулан ашиглалтанд өгснөөс гадна 2007 онд Улаанбаатарт 48, Орхон аймагт 32, Сүхбаатар аймагт 12 айлын орон сууц, Дорнод аймагт 2 давхар албаны конторын барилгыг шинээр барьж ашиглалтад өгсөн.

“Хорих байгууллагын албан хаагчдад хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журам”-ын дагуу ШШГЕГ-ын харьяа жирийн дэглэмтэй хорих анги, цагдан хорих, баривчлах байрны 1052 алба хаагчид 6 хувь, чанга дэглэмтэй хорих ангийн 680 алба хаагчид 7 хувь, хорих эмнэлгийн 140 алба хаагчид 8 хувь, гяндангийн хорих ангид ажиллаж буй 66 алба хаагчид 9 хувь, ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын Эрэн сурвалжлах албаны 9 алба хаагчид 9 хувийн нэмэгдлийг тус тус үндсэн цалингаас тооцон олгож, 2007 онд 438.1 сая төгрөгийн нэмэгдэл олгоод байна.

Иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх чиглэлээр: ШШГЕГ нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж шийдвэрлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлуудыг байгууллагаас хэрэгжүүлэх бодлого, авах арга хэмжээнд тусган, шийдвэрлэлтэд нь хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 2007 онд тус Ерөнхий газарт иргэд, байгууллагаас нийт 2719 өргөдөл, гомдол ирснээс 2538-ыг хуулийн хугацаанд хянаж шийдвэрлэн зохих хариуг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдэд өгч, 181 өргөдөл, гомдол шийдвэрлэх шатанд хянагдаж байна.

2007 онд ШШГБ-ын удирдлагаас иргэдийг хүлээн авч уулзах хуваарийг шинэчлэн 7 хоногийн ажлын өдөр бүр биечлэн уулзаж иргэдийн санал, гомдол, хүсэлтийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд үүрэг, даалгавар, чиглэл өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан. Дээрх ажлын хүрээнд давхардсан тоогоор нийт 300 гаруй иргэнийг биечлэн хүлээн авч уулзан тавьсан эрэлт, хүсэлтийг нь шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлүүлж хариу өгүүлэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 7 өргөдөл, гомдол шилжиж ирсэн бөгөөд ирүүлсэн захидал, эрэлт хүсэлт бүрийг өгсөн чиглэлийн дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, дүнг эргэж мэдээлж байсан.

Хүний эрхийн чиглэлийн сургалт, сурталчилгаа: 2007.06.12-13-ны өдрүүдэд зохион явагдсан ХЗДХЯ, НХХЯ, Шведийн институтын хамтарсан “Тэгш эрхийг хангах цогц бодлого” сэдэвт сургалт-семинарт ШШГЕГ-ын нэр бүхий 4 албан хаагч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2007.12.04-ний өдөр зохион байгуулагдсан “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт Хүний эрхийн үндэсний чуулганд тус байгууллагын нэр бүхий 66 албан тушаалтан оролцсон.

2008 оны 3 дугаар сарын 25–ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь”, “Хорих байгууллага дахь нийгмийн ажил”, “Гадаад хорих байгууллагуудын хөгжлийн чиг хандлага”, “Олон улсын Хүний эрх”, “Эрх зүйн” тойм зэрэг сэдэв бүхий 80 цагийн сургалтыг зохион байгуулсан.

ШШГЕГ-ын газар, хэлтэс, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, хорих анги, салбар нэгжийн дарга, удирдах ажилтнууд болон төвлөрсөн хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба 31 салбар нэгжийн 1636 хүнд аргачилсан сургалт, семинар, ярилцлага зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид болон олон нийтэд зориулсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хийж гүйцэтгэсэн бүтээн байгуулалтын ажил”, “Эрх зүй албаны мэдээлэл” сэтгүүлийг улирал тутам гаргаж олон нийтэд хийсэн ажил, үйл ажиллагаагаа танилцуулан тайлагнаж ирсэн.

Хорих ял эдэлж байгаа ялтны дунд явуулж буй сургалт, нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас эрхлэн гаргадаг “Өчил” сонинг улирал бүр тогтмол гарган ялтнуудын дунд тарааж байна.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр: Монгол улс дахь нийт ялтны тоо 2007 онд 6149 байсан бол 2008 оны 7 дугаар сарын байдлаар 6020 байгаа нь өмнөх оныхоос 2.1 % буурсан үзүүлэлт гарч байгаа нь энэ 2008 оны 7-р сард Монгол улсын Эрүүгийн хууль ялын бодлогод зарим өөрчлөлт орсноор 747 ялтан дэглэм буурч, 611- ялтны ялд нь өөрчлөлт орж, 705 ялтан суллагдсан нь хорих нөхцөл өөрчлөгдөн, тоон үзүүлэлтэнд зохих хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байна. Энэ нь хорих ангийн дотоод уур амьсгал, ялтны сэтгэл зүйд эергээр нөлөөлж байна.

Тайлангийн хугацаанд нийгэмд хараа хяналтгүй, орон гэргүй насанд хүрээгүй хүүхдийг албадан сурган хүмүүжүүлэх сургуулийн бүтэц зохион байгуулалт, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, түүнтэй холбогдон гарах заавар журмыг шинэчлэн улам боловсронгуй болгон гаргаж хүний эрхийн асуудлыг олон улсын гэрээ конвенциудад нийцүүлэн зохион байгуулахаар зааж өгсөн. Үүнд:

- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам”,
- “Хорих ангийн дотоод журам”,
- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан магистр, докторын зэрэг олгох сургалтанд хамрагдах журам”,
- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”,
- “Мэргэжлийн албанд томилогдохоос өмнөх сургалтын журам, хичээлийн хөтөлбөр” зэргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна.

Цаашид манай байгууллага нь хоригдогсдыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдогсдын дунд зохиох сургалт, хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлж, чанаржуулах, улмаар хорих ял эдэлж байгаа ялтны ажил, амьдрал, эрүүл мэндийн нөхцөлийг сайжруулж, олон улсын тавьж буй шаардлагад ойртуулах, тэднийг ажлын байраар ханган, хөдөлмөрөөр нөлөө үзүүлэх, албан хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг эрхэмлэн тэдний мэргэжлийн түвшин, ур чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд ажлаа чиглүүлэн ажиллаж байна.



Я.ИЖИЛМӨРӨН

(Дэлхийн Зөн ТББ-ын ажилтан)

ХҮҮХДИЙН ЭРХ - СУДАЛГААН ДЭЭР ҮНДЭСЛЭСЭН АРГА ЗҮЙ

Хүн бүр үр хүүхэд, ирээдүй хойч үеэ дэлхий ертөнцөд сайн сайхан байлгахын төлөө амьдардаг. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх явцад зөвхөн өөрийн хүүхэд бус бас бусдын хүүхдийн төлөө ажиллаж, амьдрах шаардлага хүмүүст тулгарна. Хамгийн энгийнээр хэлэхэд хүүхдийн эрхийг хүн бүр хамгаалахын төлөө ажиллах, хичээн чармайх шаардлагатай. Энэ нь магадгүй бид бүхний хэлж заншсан, хэвшмэл тунхаг мэтээр олон хүмүүст санагддаг байж магадгүй. Тэгвэл яагаад энэ нь хэвшмэл, тунхаглалын шинжтэй болчихоод байна вэ? гэдэг асуулт урган гарч ирнэ.

Хүүхдийн эрхийг үндсэн гурван хэсэгт хуваан үзэж болно.

Хангамж эдлэх. Үүнд амьдралын тохиромжтой түвшинд эрүүл чийрэг өсч, боловсрол эзэмшиж, тоглох, амрах орчинтой байх, тэнцвэртэй хооллолт зэрэг хэрэгцээт үйлчилгээг авах эрхүүд багтана.

Хамгаалуулах. Үүнд хүүхэд бүх төрлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөг болон ялгаварлагдахаас хамгаалуулах эрхтэй. Мөн урам хайрлах, зөв хүмүүжүүлэх эцэг эхийн үүрэг энэ эрхэд шууд хамаарна. Өөрөөр хэлбэл, зөв хүмүүжил олгож байна гэдэг нь хүүхдийн хамгаалуулах эрхийн урьдач нөхцөл болдог.

Оролцох буюу нийгмийн амьдралд өөрт нь хамааралтай асуудалд шийдвэр гаргах хүчин зүйлд өөрийн санаа бодлоо илэрхийлж, нийгмийн амьдралд оролцох эрхтэй.

Эдгээр эрхийг хүүхэд бүхэн цогцоор нь эдлэж байна уу гэвэл аль ч улсад бүрэн дүүрэн хэрэгжих боломж бүрддэггүй. Хүүхдийн бүхий л эрхийг хэрэгжүүлмэгц хүүхэд өөрийн үүрэг хариуцлагаа умартаж эхэлдэг байна. Тийм ч учраас хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ үүргийг ухамсарлуулах сурган хүмүүжүүлэх арга зүйг боловсруулах ёстой.

Хүүхдийн эрхийг хамгаалах орчинг төрийн болоод гэр бүлийн гэсэн хоёр түвшинд үндсэнд нь хувааж болох юм.

Төрийн түвшин гэдэг нь хүүхдийн эрхийг хамгаалахаар гаргасан хууль тогтоомжууд, соёрхон баталсан олон улсын конвенциуд, үзэл баримтлалууд, хэрэгжүүлэх арга хэмжээ, сургууль цэцэрлэгийн хангамж, сурган хүмүүжүүлэх, боловсрол олгох зэргийг багтааж болно. Д. Лүндээжанцан, Ч. Энхбаатар нарын бичсэнээр “Хүний эрхийг хуулиар тунхаглаад зогсохгүй тэдгээрийг хэрэгжүүлэх бодит нөхцөл, бололцоогоор хангах ёстой. Үндсэн хуульд зааснаар хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг төр хариуцдаг”¹.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид Монгол Улс 1990 онд нэгдэн орж, 1996 онд Хүүхдийн эрхийн тухай хууль батлагдсанаар хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндсийг бүрдүүлж, хүүхэд-гэр бүл төвтэй нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх болсон.² Хүүхдийн эрхийг хамгаалах талаар манай улсын хууль тогтоомжид маш олон сайн заалт байдаг боловч хүүхдийн эрх зөрчигдөх явдал багагүй байна³.

Харин гэр бүлийн орчин гэдэгт эцэг, эхийн хайрлан энэрэх чадвар, сурган хүмүүжүүлэх арга барил, гэр бүлийн халуун дулаан уур, амьсгалыг бүрдүүлэхийн төлөө хичээн чармайж буй зан байдлыг багтаана.

Энэхүү хоёр түвшний огтлолцол нь хүүхэд бусад хүмүүстэй хэрхэн харилцаж буй байдал дээр илрэн гардаг. Тухайн хүүхдийн гэр бүлийн орчин тавлаг, хүүхдийнхээ ахуй байдлыг хангах боломжтой байхад өөр нэгэн хүүхэд гудамжинд лааз түүгээд амьдарч байж болно. Эдгээр хоёр амьдралыг харьцуулахад нэг нь хүүхдийн эрхээ бүрэн дүүрэн эдэлж, нөгөө нь эрх нь зөрчигдөн хөдөлмөр эрхэлж байгаа дүр зураг харагдана. Энэ хоёр хүүхдийг гаднаас нь харахад эрхийн зөрчил нь харилцан адилгүй түвшинд байгаа нь анзаарагдах боловч, дотоод мөн чанарыг нь олохыг эрмэлзэн, тухайн хүүхдүүдээс санал бодлыг нь асуувал магадгүй гудамжинд лааз түүж байгаа хүүхэд нь өөрийгөө илүү жаргалтай, эрх чөлөөтэй мэтээр хариулж болох юм. Харин халуун дулаан гэртээ гэдэс цатгалан, “хичээлээ хий” хэмээн байнга шаардуулж, шахуулдаг хүүхэд өөрийгөө туйлын их зовлонтой амьдралтай гэж төсөөлдөг байж болно. Гэхдээ эдгээр хариултууд нь бүгд бүрэн дүүрэн хариулт биш бөгөөд гол нь энэ бол тухайн хүүхдийн өөрийнх нь хариулт бөгөөд энэхүү хариултыг зөвөөр дүгнэхэд насанд хүрэгчдийн оролцоо байнга хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хүүхдийнхээ үзэл бодлыг мэдэхийн тулд насанд хүрэгчид хүүхдийн үгийг ойлгох арга зүйтэй байх ёстой юм. Тухайлбал, хөдөө малчин айлд өсч буй хүүхэд, хот газар өсч буй хүүхэд, жижиг суурин газар өсч буй хүүхдийн аж байдал, сэтгэлгээний талаар

¹ Д. Лүндээжанцан, Ч. Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ 2000. 107 дах тал

² Хүүхэд ба хууль ёс. (Хуульчдад зориулсан гарын авлага) УБ 2008. 5 дах тал.

³ Мөн тэнд. 9 дэх тал.

тухайн байгаль, цаг уурын орчин, эдийн засгийн хөгжил, ястан үндэстний уламжлал, зан заншлын нөлөөлөл, хүмүүжүүлэх арга ухаан зэргийг өргөн хүрээтэйгээр судлан үзэж, эрдэм шинжилгээний бүтээл гаргах шаардлагатай байна.

Энэ талаар ХБНГУ-ын эрдэмтэн Удо Б. Баркманн “Нийтийн хүртээл болсон нь ховор хэдий ч хүүхэд, залуучууд болон эмэгтэйчүүдийн асуудлыг тухайлан авч үзсэн судалгаанууд бас ч хийгдсэн бөгөөд хачирхалтай нь эдгээрийн аль нь ч Монголын нийгмийн хамгийн жижиг хэрнээ хамгийн чухал бүрдүүлэгч хэсэг болох гэр бүлийн асуудлыг орхигдуулсан байдаг юм”⁴ гэжээ. Монголын ихэнх гэр бүл шилжилтийн явцад санхүүгийн талаар хүндхэн шахалтад орцгоосон⁵. Гэтэл “иргэд гэрлэснээр нэг нэгнийгээ болон гэр бүлийн гишүүдийг тэжээн тэтгэх, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн аж ахуйг хамтран хөтөлж, амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх хууль зүйн үүрэгтэй болдог”⁶. Чухамдаа цогц суурь судалгаагүй учраас нэг хэвшмэл арга барилаар, зөвхөн хүүхдийн материаллаг орчныг бүрдүүлэхийн төлөө хүүхдийн эрхийн олонхи байгууллагууд анхааран ажиллаж байна гэж хэлж болно. Мэдээж хүүхдийг ойлгох, эрхийг нь хэрэгжүүлэхийг хэн хүнгүй зорьж байгаа хэдий ч энэ нь дээр өгүүлсэн цогц суурь судалгааны хомс байдлаас амьдралд төдийлөн хэрэгжихгүй байгаа юм.

Аливаа эрхийг хамгаалахад эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчил гарсан тохиолдолд хамгаалах, гарсан сөрөг үр дагаврыг арилгахын төлөө ажиллах гэсэн ерөнхий гурван үе шат байдаг гэж үзвэл өнөөгийн монголын хүүхдийн эрх хамгаалал нь зөвхөн зөрчил гарсан тохиолдолд хамгаалахыг оролдож буй үе шатанд л байна. Урьдчилан сэргийлэх болон гарсан үр дагаврыг арилгах үе шатууд суурь судалгаагүйгээс тэр бүр хэрэгжиж чадахгүй байна гэж хэлж болно. Тиймээс хүүхдийн эрхийн судалгааг цогц байдлаар хийх шаардлагатай байна.

Дээр өгүүлсэнчлэн хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх гол нөхцөл нь түүний үүргийг ухамсарлуулах явдлыг хавсарч байдгаараа онцлог юм. Тухайлбал насанд хүрсэн хүн бие даан шийдвэр гаргадаг бөгөөд насанд хүрсэн хүнийг сурган хүмүүжүүлэх төрийн болоод гэр бүлийн орчинд хэрэгжих үүрэг гэж бараг ярихгүй. Харин хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ үүргийг ухамсарлуулах үүрэг гэж бий. Энэ үүргийг хэрэгжүүлэхэд төрийн оролцооноос илүү гэр бүл дэх эцэг, эхийн оролцоо илүү байдаг. Тухайлбал лалын шашинтай Баян-Өлгий аймгийн гэр бүл дэх хүүхдийн эрхийн нарийвчилсан судлагаа хийвэл төвийн бүсийн бусад аймгуудын нийтлэг хэв шинжээс өөр дүр зураг гарна. Эсвэл Хөвсгөл аймгийн цаатан гэр бүлийн хүүхэд хүмүүжүүлэх арга барилыг Улаанбаатар

⁴ Удо Б. Баркманн. Орчин цагийн монголын тухай өгүүллүүд. УБ 2008. 242 дах тал

⁵ Мөн тэнд. 251 дах тал

⁶ Д. Лүндээжанцан, Ч. Энхбаатар. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ 2000. 107 дах тал

хотынхтой, байранд амьдардаг гэр бүлийг гэрт амьдардаг гэр бүлтэй гээд монголын онцлогт тохирсон судлагааг бүрэн цогцоор нь бүс бүрээр, харилцан ялгавартай хийж чадвал төрийн болоод төрийн бус байгууллагуудын хүүхэд хамгааллын ажилд дэвшилт гарч, монгол сэтгэлгээтэй иргэн өсөн бойжиход илүү түлхэц өгөх юм.

Ёс заншил, улс орны хөгжлийн үе шат зэрэг хүчин зүйлээс шалтгаалж гадаад орны туршлагыг шууд монгол хөрсөнд буулгах боломжгүй байдаг. Жишээ нь, монгол ёс заншлын дагуу хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх буюу өөрийн үзэл бодлоо өөрт нь хамаарах асуудалд шийдвэр гарган оролцох боломж хомс байдаг. Манай ёс заншлаар шийдвэр гаргахад битгий хэл, хүүхэд ахмад хүмүүсийн ярианд оролцох ёсгүй байдаг. Цаашилбал эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ахуй байдал тус бүртээ өөр байдаг учир үндсэндээ эцгийн эрхт ёсыг баримталдаг монгол гэр бүлийн орчинд зөвхөн хүүхэд гэдэг ерөнхий байдлаар авч үзэх бус харин эрэгтэй хүүхэд, эмэгтэй хүүхдийн байдал хэмээн нарийвчлан авч үзэх шаардлагатай. Хөдөөгийн малчин айлаар жишээ авбал эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эрхлэх ажил тус бүртээ хуваарилагдсан байдаг бөгөөд бидний хэлж заншсанаар эрэгтэй хүүхэд гэрийн гаднах ажилд илүү хуваарилагддаг бол эмэгтэй хүүхэд гэрийн доторх ажил буюу тогоо шанага барих, цагаан идээ боловсруулах ажилд хуваарилагддаг. Гэрийн гадуурх ажилд илүү хуваарилагдаж байгаагийн хувьд эрэгтэй хүүхэд эцэг, эхийн хараа хяналтаас арай холуур байдаг учир тамхи татах, архи уух зэрэг муу зуршилд автах нь илүү байдаг.

Мөн хөдөөгийн хүүхдүүдийн тэр дундаа өсвөр насны хүүхдүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон психологийн асуудлыг тусад нь нарийвчлан үзэх шаардлагатай. Үүнд өрөө тасалгаагүй монгол гэрт эцэг, эхтэйгээ нэг дор амьдардаг гэх зэрэг сөрөг үр дагавруудаар тайлбарлаж болно.

Нийгмийн болон үндэсний заншлын хүчин зүйлийг үнэлэхгүйгээс хүүхдийн эрх хамгаалал нь үндсэндээ хүүхдийг цуглуулж, хооллож, хувцасладаг газруудын дүр зургаас хэтрэхгүй болж байна. Зах дээр ундаа зарж, машин угааж байгаа хүүхдийг хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд гэж үзэх юм бол хөдөө гэртээ өглөөнөөс орой болтол мал аж ахуй эрхэлж, эцэг эхдээ туслаж, өдөржин хонь хариулж байгаа хүүхдийг мөн хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлж буй хүүхэд гэж үзэх шаардлагатай болно. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенцид заасан “Хүүхдийн хүнд хөдөлмөр”-ийг мөлжих гэдэг өрний орны тодорхойлолтыг авч үзвэл энэ мэт нэлээд олон төрлийн хэлбэрээр монголчууд хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж байгаа болж таарна.

Дүгнэлт.

Хүүхдийн эрхийг хамгаалахын тулд хүүхдийн эрх, хамгааллын цогц суурь судалгааг хийх шаардлагатай бөгөөд дараах онцлогуудыг тусгаж, арга зүйгээ боловсруулмаар байна.

- Бүс нутгийн эдийн засаг, зан заншил, шашин шүтлэг, байгаль, цаг уурын байдал.
- Хүүхдийн нас, хүйсийн байдал.
- Тухайн бүсийн насанд хүрэгчдийн байдал нь хүүхдийн хүмүүжилд нөлөөлдөг учир тухайн бүсийн насанд хүрэгчдийн төлөвшил, улмаар гэмт хэрэгт холбогдсон шалтгаан нөхцөл.
- Олон Улсын конвенцууд болон дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжиж байгаа буюу амьдралд хэрэгжихгүй байгаа конвенц, хууль тогтоомжуудын зөрчилдөөний нөхцөл.
- Хүмүүжлийн чанартай арга хэмжээ авах, боловсролын байгууллага ашиглахад тухайн бүс нутгийн юуг түшиглэж болох.
- Хүүхдийн цөм орчин болох гэр бүл, эцэг эхийн чадвар, нөлөөлөл
- Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг авахад ямар нөхцөл шаардагдах зэрэг олон талт хүчин зүйлийг судлах шаардлагатай.

Хүүхдийн эрхийн талаарх цогц суурь судалгаа үгүйгээс эцэг, эх, багш, сурган хүмүүжүүлэгч нар, нэн ялангуяа гадны донор байгууллагууд монгол амьдралын хэрэгцээнд нийцсэн хүүхдийн эрхийн хамгаалалын талаарх зохистой, цогц арга хэмжээг авахад хүндрэлтэй байна. Үүний нэг анхаарууштай жишээ нь 2000 оны эхээс Монголд өргөн дэлгэр хөгжиж буй хүүхдийн оролцооны үйл ажиллаганууд юм. Хэдийгээр хүүхэд өөрт хамаатай асуудал дээр дуу хоолойгоо гаргаж шийдвэр гаргахад оролцох чадавхийг суулгах анхны зорилготой боловч, өнөөгийн хүүхдийн оролцооны үйл ажиллагааны үр дүнд хэлснээ амьдралд хэрэгжүүлдэггүй “уран илтгэгчийн” шинэ залуу эгнээ бэлтгэгдэн гарч байна. Иймэрхүү үр дагаварууд нь хүүхдийн эрхийн асуудлуудыг шийдвэрлэхдээ Монгол улсын дотоодын онцлогоос шалтгаалан нарийн судалгаа шинжилгээн дээр үндэслэн, зөвхөн олон улсын хэм хэмжээнд баригдалгүй үндэсний онцлогт тохирсон бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг анхааруулж байна.

Хэрэв ийм судалгаа хийж үүнийгээ төрийн үйл ажиллагаанд шат дараатайгаар тусгаж чадвал өөрийн орны төсвийн төдийгүй гадаад орнуудын тусламжийг зөв зохистой, үр дүнтэй зарцуулахад томоохон хувь нэмэр болж, эрхээ эдэлж, үүргээ ухамсарласан Монголын хойч үе бэлтгэгдэхэд түлхэц болно.



Б.БАТЦЭЦЭГ

Хүний эрхийн Үндэсний Комиссын
референт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ
НУБ-ЫН КОНВЕНЦИЙГ СОЁРХОН БАТЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

Дэлхийн хүн амын 10 хувь орчим нь буюу 650 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй амьдардаг гэсэн тооцоог Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан. Энэ тоон дээр хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгэн дотны хүнээ харж хандахын тулд суралцаж, хөдөлмөрлөж, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байгаа гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдын тоог нэмбэл ойролцоогоор 2 тэрбум хүн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн асуудалтай амьдарч байна.

Дэлхийн хүн ам өсөхийн хирээр хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо ч улам бүр нэмэгдэж байгаа юм. Нөгөө талаас, ядуурал, байгалийн гамшиг, тогтворгүй байдал, осол гэмтэл, эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдлаас хүн хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өссөөр байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, тайлан харуулж байна. Ялангуяа, ийм байдал хөгжлөөр буурай болон хөгжиж байгаа улс орнуудад харьцангуй өндөр хувьтай байдаг. Хэнд ч, хэдийд ч тохиолдож болох учраас хөгжлийн бэрхшээлийн асуудал хүн бүрийн асуудал мөн билээ.

Өнөөдөр аль ч улс оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмээс тусгаарлагдсан, хязгаарлагдмал орчинд амьдарч байна. Тэд бусдын л адил амьдрах, хийж бүтээх хүсэл, тэмүүллээр дүүрэн байдаг боловч сурах, хөдөлмөрлөх, нийгмийн үйл хэрэгт оролцох, найзалж нөхөрлөх, гэр бүл зохиох, үр хүүхдээ өсгөх итгэл найдвар бага, эмнэлэг, сургууль, дэлгүүрээр үйлчлүүлэх, тээврийн хэрэгслээр зорчих, хэрэгцээтэй мэдээллээ бүрэн дүүрэн хүлээж авах боломжоор хязгаарлагдмал орчинд амьдарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгарч буй нэг хүндрэл бол ядуурал. Амьдралын хүнд хэцүү нөхцөл, хоол хүнсний дутагдал, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүйгээс ядуу хүн хөгжлийн бэрхшээлтэй болох нь элбэг байхад сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх боломж, орчин хязгаарлагдмал учраас хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн олонх нь ядуу амьдарч байна. Ядуурал хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрх зөрчигдөхөд хүргэдэг гол шалтгаан юм.

Түүнчлэн нийгмийн бусад гишүүдийн үл тоомсорлол, боломж, чадавхыг нь үгүйсгэх хандлагын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдөхөд хүрч байна. Өнгөрсөн түүхийн ихэнх хугацаанд, дэлхийн улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн харилцаанд эрүүл иргэдийн нэгэн адил оролцох эрхтэй болохыг нь үл хүлээн зөвшөөрч, тэднийг гагцхүү “төрийн тусламж, дэмжлэгийг хүртэгч”, “эмнэлэг, нийгмийн халамжийн үйлчилгээний объект” мэтээр хандаж ирсэн. Ийм ч учраас утга зохиол, соёл урлаг, нийгмийн шинжтэй сурталчилгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өрөвдөж энэрэх, туслахыг уриалсан өнгө аяс зонхилж, харин сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн амьдрал оролцохыг нь дэмжих, тэгш боломжийг бий болгох утга агуулга төдийлөн хөндөгддөггүй байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохуурхах, нэр төрийг нь доромжлох, элдэв нэр хоч өгөх, цэрвэх, цээрлэх хандлага ч нийгэмд байдгийг үгүйсгэх аргагүй. Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээсээ ичиж зовох, ил гаргахаас нуух нь бидний эргэн тойрон байдаг асуудал боловч ингэснээрээ тэдгээр дотны хүмүүсийнхээ “хүн хэмээх” эрхэм чанарыг үгүйсгэж байгаа болохоо хүмүүс тэр бүр анзаардаггүй. Тэргэнцэртэй, таягтай гэх зэргээр хүнийг нь биш, тусгай хэрэглэгдэхүүн, согоогоор онцлон нэрлэж, тахир дутуу гэх мэтээр өөрсдөө ч хэлэхээс эвгүйцэм нэр томъёогоор дуудах нь ч мөн хүнлэг бус харьцаа болно.

Хүн зөвхөн согог, гэмтлийнхээ улмаас хөгжлийн бэрхшээлтэй болдоггүй бөгөөд бие эрхтний согог, гэмтэл нийгмийн орчин, хязгаарлалттай нэгдэн нийлж хөгжлийн бэрхшээлийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, тэргэнцэр ашигладаг хүн ямар нэг ажил хийх чадваргүйдээ биш, гагцхүү түүний ажлын байр тэргэнцэртэйгээ орох, гарах, ажиллах нөхцөлийг бий болгож чадаагүй учраас тэдний ихэнх нь хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Үүний нэгэн адилаар сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд эрүүл хүүхдүүдийн нэгэн адил суралцах оюуны чадавхгүйдээ биш, харин тэдний хэрэгцээг хангахуйц сургалтын орчин, гарын авлага, багш байхгүйгээс, сургууль тэдэнд хүртээмжтэй бишээс тэр бүр амжилттай суралцаж чаддаггүй юм.

Хөгжлийн бэрхшээл нь нийгмийн орчин, хөгжлийн түвшингээс хамаарч үргэлж өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт юм. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дагаад хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээг хангах тоноглол, хэрэглэгдэхүүн улам бүр боловсронгуй болж байна. Жишээлбэл, сул харааг /хурц миофиа буюу зөвхөн мөрөө л хардаг/ нөхөх линзийг хэрэглээнд нэвтрүүлсэн хөгжингүй улс оронд сул хараатай хүнийг хөгжлийн бэрхшээлтэйд тооцохооргүй болж байгаа нь хөгжлийн бэрхшээл орчин нөхцөл, улс орны хөгжлийн түвшнээс хамааралтай болохыг харуулж байна.

Хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал дараах байдлаар тусгагдсан байв.

🕒 Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)

Тодорхой зарчмуудыг уриалсан чанартай баримт бичиг хэдий ч хүний эрхийн олон улсын эрх зүйн бусад баримт бичгийн суурь хэм хэмжээ юм. Тунхаглалын 7 дугаар зүйлд хүн бүрийн хуулийн өмнө адил тэгш байх болон алагчлалд өртөхгүй байх, 25 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдолд тэтгэмж авах эрхтэй болохыг баталгаажуулсан.

🕒 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)

ИУТЭОУП-ын 2 дугаар зүйлд Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангахаар заасан. Пактад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар тусгайлсан заалт байхгүй ч дээрх зүйлийн төрсөн буюу бусад байдлаар гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулж ойлгоно.

🕒 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт (1966)

ЭЗНСЭОУП-д ч мөн дээрхийн нэгэн ижил заалт бий. 1994 онд энэ Пактын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооны 5 дугаар ерөнхий зөвлөмж гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүйсийн хувьд алагчлах болон хөдөлмөр эрхлэх, гэр бүлийг хамгаалах, хүрэлцэхүйц амьжиргаатай байх, бие бялдар, сэтгэхүйн хувьд эрүүл байх, сурч боловсрох, соёлын амьдралд оролцох, шинжлэх ухааны хөгжил дэвшлийн үр шимийг хүртэх эрхээ эдлэхэд алагчлах явдлыг устгахыг оролцогч улсуудад зөвлөжээ.

🕒 Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (1979)

Конвенцууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд чиглэгдсэн тусгай заалт байхгүй. Харин Эмэгтэйчүүдийг алагчлах явдлыг устгах хорооны 18 дугаар ерөнхий зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь давхар алагчлалд өртөж буй нэн эмзэг бүлэгт учраас оролцогч улсууд тайлан илтгэлдээ тэдний асуудлыг заавал оруулах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын арга хэмжээ ижил тэгш хамрагдах боломж олгох, нийгэм, соёлын амьдралд бүрэн дүүрэн оролцуулах нөхцөлийг бий болгохыг зөвлөсөн.

 *Хүүхдийн эрхийн тухай конвенци (1989)*

НҮБ-ын хүний эрхийн суурь гэрээнүүдээс хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг тусгасан анхны гэрээ нь Хүүхдийн эрхийн тухай конвенци юм. Конвенцийн 2 дугаар зүйлд хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлах явдлыг хориглож, хүүхэд бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээсээ үл хамаарч Конвенцид заагдсан эрхийг бүрэн дүүрэн эдлэх ёстой болохыг заажээ. Түүнчлэн Конвенцийн 23 дугаар зүйлд “Оролцогч улсууд өөрийнхөө боломжид түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой хүүхдийн нэр төрийг хүндэтгэн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжтой орчинд бүрэн дүүрэн, зохистой амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой хүүхдийг асран хамгаалахад бололцооныхоо хэрээр туслалцаа үзүүлэх, онцгой анхаарал халамж тавих үүрэгтэй” болохыг заасан.

 *Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэргэжлийн нөхөн сэргээлт ба хөдөлмөр эрхлэлтийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенци (1983)*

Конвенцийн 2 дугаар зүйлд “Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн талаар үндэсний бодлого боловсруулан хэрэгжүүлж, тухай бүр эргэн авч үзэж байх үүрэгтэй” болохыг заажээ. Үндэсний бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг зохих мэргэжлийн нөхөн сэргээх арга хэмжээнд хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөрийн нээлттэй зах зээлээс ажил олох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэх ёстой бөгөөд түүнийг боловсруулахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн адил тэгш байдлыг баталгаажуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар мэргэшсэн байгууллагуудыг оролцуулахыг гэрээнд оролцогч улсуудад үүрэг болгосон.

 *Оюуны хомсдолтой хүний эрхийн тухай тунхаглал (1971)*

Оюуны хомсдолтой хүмүүс бусад хүний эдэлдэг эрхийг дээд хэмжээгээр эдлэх ёстойг тунхагласан.

 *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал (1975)*

Тунхаглал нь “хөгжлийн бэрхшээл” гэсэн ойлголтыг тайлбарласан анхны олон улсын баримт бичиг юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүн иргэний, улс төрийн, нийгмийн болон соёлын бүхий л эрхийг бусдын нэгэн адил эдлэх ёстой болохыг тунхаглан зарлажээ.

🕒 Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал (1979)

Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүн бүр олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд заасан бүх эрхийг эдлэх ёстой болохыг тунхагласан.

🕒 Сэтгэцийн өвчтэй хүнийг хамгаалах, сэтгэцийн эмчилгээ сувилгааг сайжруулах зарчмууд (1991)

Зарчмуудын зорилго нь оюуны хомсдолтой хүмүүсийг хамгаалахад чиглэгдсэн нийтлэг стандарт тогтоох явдал юм. Хүн бүр хамгийн дээд зэргийн сэтгэцийн эмчилгээ, үйлчилгээг хүртэх эрхтэй ба сэтгэцийн өвчтэй хүмүүс нь хүн ёсоор, нэр төрөө хүндэтгүүлэн харьцах эрхтэй болохыг зарчмуудад заасан. Мөн сэтгэцийн өвчтэй хүмүүс эдийн засгийн, бэлгийн болон бусад хэлбэрийн мөлжлөг, бие махбодийн хүчирхийлэл, хүнлэг бус хэрцгий хандахаас хамгаалуулах эрхтэй болохыг баталгаажуулсан. Сэтгэцийн өвчтэй хүн иргэний, улс төрийн эрхээ бусдын нэгэн адил эдэлж, алагчлалаас ангид байх эрхтэй бөгөөд сэтгэцийн өвчин хүнийг эрх зүйн чадамжгүй байдалд хүргэж байгаа бол энэ талаар хараат бус шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан байх ёстойг дэлхий нийтийн зарчим болгожээ.

🕒 Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх дэлхийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (1982)

1981 онд зарлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний олон улсын жилийн үр дүнд энэхүү баримт бичиг боловсруулагджээ. Мөрийн хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сэргээх, нөхөн сэргээх дэлхий нийтийн цогц стратегийг тодорхойлсон юм. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд хүний эрхийн үүднээс хандахыг чухалчилсан анхны баримт бичиг байв.

🕒 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмүүд (1993)

Энэ баримт бичиг улс орон бүрийн ёс суртахууны хүчин зүтгэлийн үр дүнд хэрэгжих ёстойг Стандарт дүрмүүдэд заасан байдаг. Тэгш оролцоо, тэгш оролцооны зорилтот хүрээнүүдийг тодорхойлж, авах арга хэмжээ, хэрэгжилтийг хянах механизмыг цогц байдлаар тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавих тусгай субъектийг бий болгосноороо Стандарт дүрмүүд онцлогтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмүүдийн хэрэгжилтэд НҮБ-ын тусгай илтгэгч хяналт тавьдаг.

 *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх Бээжингийн тунхаглал (2000)*

2000 онд БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан Төрийн бус байгууллагуудын Дэлхийн Бага Хурлаас батлан гаргасан энэ тунхаглалаар хөгжлийн бэрхшээлтэй хүний хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх, тэгш оролцоог баталгаажуулахад чиглэгдсэн арга хэмжээг тодорхойлсон.

 *Бивакогийн мянганы хөтөлбөр (2003)*

Ази Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссын 2002 оны 54/2 дугаар тогтоолоор 2003-2012 оныг Ази Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах, тэдний оролцоог хангасан, саад тотгоргүй, эрхэд тулгуурласан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилго бүхий “Ази, номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арван жил” болгон зарлаж, арван жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол механизм болох Бивакогийн мянганы хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрт 2012 он гэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангасан, саад тотгоргүй, эрхэд тулгуурласан нийгмийг цогцлоон бүрдүүлэхэд чиглэгдсэн 21 зорилт, зорилтуудад хүрэх 17 стратегийг тодорхойлсон байна.

Хэдийгээр олон улсын хүний эрхийн гэрээ, конвенциор хүн бүрт хамааралтай эрхийг баталгаажуулсан ч хөгжлийн бэрхшээлээс үүдэн бий болдог нийгмийн амьдралд оролцох тэгш оролцоо, барилга байгууламж, нийгмийн орчин, мэдээллийн хүртээмжтэй байдал, хараат бус амьдрах эрхийн асуудал тусгагдаж чадаагүй юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах талаар урьд өмнө нь гарч байсан олон улсын баримт бичгүүдийн ихэнх нь заавал биелэгдэх хууль зүйн хүчин чадалтай бус, тунхаглал, зөвлөмжийн шинж чанартай байсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлыг тусгайлсан зохицуулалт бүхий гэрээ бий болох хэрэгцээ шаардлага байсныг илтгэж байна.

Энэ асуудлыг олон улсын түвшинд хэлэлцсэний үр дүнд 2001 оны 12 сарын 19-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56/168 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх тусгай конвенцийн эх бичвэрийг боловсруулах эсэх асуудлыг шийдвэрлэх Түр хороог байгуулсан бөгөөд 2003 оны 6 сард зохион байгуулагдсан Түр хорооны 3 дугаар чуулганаар конвенци боловсруулахыг дэмжиж, 2004 оны 2 сард ажлын хэсгийг томилжээ. Ажлын хэсэг 2 жил гаруй хугацаанд ажилласны эцэст 2006 оны 8 сарын 25-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын

конвенцийн эх бичвэрийг боловсруулж дууссан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци нь богино хугацаанд, иргэний нийгмийн байгууллагуудын өргөн оролцоотойгоор боловсруулагдаж, хамгийн хурдан хүчин төгөлдөр болж байгаагаараа НҮБ-ын бусад хүний эрхийн гэрээнүүдээс онцлогтой юм.

2006 оны 12 сарын 13-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61/106 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг баталж, конвенцид гарын үсэг зурах хугацаа 2007 оны 3 сарын 30-ны өдрөөс нээгдсэн. 2008 оны 4 сарын 3-ны өдрийн байдлаар конвенцийг 20 дахь улс соёрхон баталж, конвенцийн 45 дугаар зүйлд заасны дагуу 2008 оны 5 сарын 3-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон билээ. Одоогоор уг конвенцийг 137 орон дэмжиж гарын үсэг зурж, 41 орон соёрхон батлаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенцийг дэмжигчдийн гаргаж байсан гол үндэслэлүүдийг нэг нь шинээр батлагдах конвенцийн дагуу НҮБ-ын бүтцэд бий болгох Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны ач холбогдлын талаарх асуудал байв. Шинээр батлагдсан гэрээний хэрэгжилтийг хянах, хувь хүний гомдлыг шийдвэрлэх төдийгүй НҮБ-ын бодлого, хөтөлбөрүүд, эрх зүйн баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлыг тусгахад конвенцийн дагуу байгуулагдах Хорооны үүрэг нэн чухлыг тэд онцолж байлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгохыг гэрээний талуудад хууль зүйн үүрэг оногдуулхуйц түвшинд гаргаж тавьсан юм. Конвенци урьд өмнө нь батлагдсан НҮБ-ын хүний эрхийн суурь гэрээнүүдэд нэмэлт болох баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл, уг конвенциор ямар нэг шинэ эрх, эрх чөлөөний төрлийг бий болгож, баталгаажуулаагүй бөгөөд гагцхүү, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдлэх наад захын эрх, эрх чөлөө, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар гэрээнд оролцогч улс, бусад этгээдийн хүлээх үүргийг нарийвчлан тодорхойлжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци нь бүтцийн хувьд оршил хэсэг, 50 зүйл, нэмэлт протоколоос бүрдэх бөгөөд конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, тэдний салшгүй нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн дэмжих явдал бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр эрх зүйн этгээд болохыг нь хүлээн зөвшөөрч, эрүү шүүлт, мөлжлөг, хүчирхийллээс ангид байх явдлыг баталгаажуулан, тэдний амь нас, халдашгүй чөлөөтэй байдал, үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй зорчих эрх чөлөө, хувийн амьдралын халдашгүй байдлыг хамгаалах нь зорилготой. Конвенци хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг эдийн засаг, нийгэм, улс төр, хууль, соёлын амьдралын бүхий л хүрээнд хамгаалах, үл алагчлах

харьцаа, тэгш хандлагыг боловсрол, эрүүл мэнд, хуулийн байгууллагууд, соёл, биеийн тамир, спортын үйл ажиллагаанд, ажлын байр, гэр бүлийн амьдралд төлөвшүүлэхэд чиглэгдсэн.

Конвенцид “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь орчны бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулхуйц болсон этгээдийг хэлнэ” гэж тодорхойлсон боловч энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх “туйлын” тодорхойлолт биш юм. Учир нь конвенцийн оршил хэсэгт хөгжлийн бэрхшээл нь байнга өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт бөгөөд хувь хүний бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болдгийг хүлээн зөвшөөрсөн. Өөрөөр хэлбэл, конвенцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэг ойлголтыг томъёолхоосоо илүүтэйгээр ийм бүлэгт нэн тэргүүнд хамрагдах ёстой хүмүүсийн шинж байдлыг тодорхойлсон юм. Конвенцийн тодорхойлолт нь аливаа улс орон үндэсний хууль тогтоомжийнхоо хүрээнд түр зуурын хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэсэн ангилалд хамруулж, эрхийг нь хангах, хамгаалах явдлыг хязгаарлахгүй.

Конвенцийн зүйл заалтыг тайлбарлах, түүнийг амьдралд хэрэгжүүлэхэд гэрээнд оролцогч улсуудад чиглэмж болох ерөнхий зарчмуудыг 3 дугаар зүйлд тодорхойлсон. Үүнд:

- ☞ Сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, эрхэм чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;
- ☞ Алагчлахгүй байх;
- ☞ Нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;
- ☞ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;
- ☞ Тэгш боломж олгох;
- ☞ Хүртээмжтэй байх;
- ☞ Эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх;
- ☞ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах;

Эдгээр зарчмуудыг үндэслэн конвенцийг баталсан улс орнууд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх нөхцөл байдлыг аажмаар бий болгох үүднээс оролцогч улс бүр олон улсын эрх зүйн дагуу нэн даруй үүсэх энэхүү конвенциор хүлээлгэсэн үүрэгтэй үл харшлах байдлаар өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэнэ.” гэж заасан.

Энэ заалт нь гэрээнд оролцогч улсуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг аажмаар, шат дараатай бий болгох, ингэхдээ өөрийн боломжит нөөцөө дээд хэмжээгээр ашиглах үүрэг хүлээлгэж байна. Иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах үүднээс төр хангалттай арга хэмжээ авсан эсэхийг нөөц бололцоогоо хэр үр дүнтэй, хүртээмжтэй байдлаар ашигласныг үндэслэн тодорхойлдог. “Боломжит нөөц бололцоо” гэдэг нь тухайн улсын дотоодын нөөц, гадаад эх үүсвэрээс авсан тусламж дэмжлэгийг хамтад нь ойлгоно.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг бий болгоход цаг хугацаа, хөрөнгө төсөв шаардлагатай учраас ийм нөхцлийг аажмаар ахиц гаргах замаар бий болгохыг гэрээнд оролцогч улсуудад зөвшөөрдөг. Гэсэн хэдий боловч иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх нөхцлийг гэрээнд оролцогч улс аль болох шуурхай бий болгох ёстой.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхээс ялгаатай нь иргэний болон улс төрийн эрхүүдийг аажмаар ахиц гаргах замаар хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд эдгээр эрхүүдийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг олон улсын эрх зүйн дагуу гэрээг хүлээн зөвшөөрсөн улс орнуудад нэн даруй үүсдэг. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенциор баталгаажуулсан иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөөг аливаа улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болмогц тухайн улс ямар ч тайлбаргүйгээр, нэн даруй хэрэгжүүлэх үүрэгтэй юм.

Конвенцийг хүлээн зөвшөөрсөн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар аливаа шийдвэр гаргахдаа тэдний төлөөллийг оролцуулах ёстой.

Конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх чиглэгдсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг бий болгох, сайжруулах явцад болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахдаа оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэднийг төлөөлөх байгууллагыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй сайтар зөвшилцөж, оролцоог хангана.” гэж заасан. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой шийдвэр гаргах төдийгүй конвенцийн хэрэгжилтийг хянах хороо байгуулах, конвенцийн хэрэгжилтийн тухай Засгийн газрын илтгэл тайлан боловсруулахад ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцоог хангах тухай заалт Конвенцид бий.

Конвенциор баталгаажуулсан эрхүүдийн тухайд гэрээг хүлээн зөвшөөрсөн улс орнууд тэдгээрийг хүндэтгэн сахих, хамгаалах, хангах үндсэн гурван үүрэг хүлээж байна.

- ☺ **“Хүндэтгэн сахих”** гэдэг нь гэрээг хүлээн зөвшөөрсөн улсын зүгээс иргэдээ гэрээгээр баталгаажуулсан эрхийг гэдлэхэд нь хөндлөнгөөс оролцохгүй, зөрчихгүй байхыг хэлнэ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний зөвшөөрөлгүйгээр биед нь эмнэлгийн туршилт хийхгүй байх, хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас хэн нэгний сургуульд сурах боломжийг хязгаарласан хууль тогтоомж гаргахгүй байх зэргээр төр гэрээгээр баталгаажуулсан эрхийг зөрчихгүй байх ёстой.
- ☺ **“Хамгаалах”** гэдэг нь оролцогч улс аливаа гуравдагч этгээд гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг зөрчихөөс төр хамгаалах үүрэгтэй болохыг ойлгоно. Тухайлбал, конвенциор баталгаажуулсан эрхийг зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлагыг хуульчлах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх замаар төр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүргээ хэрэгжүүлдэг. Мөн Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангах үүднээс тэдний ажлыг байрыг тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглох шаардлагыг ажил олгогчид тавих нь конвенциор хүлээсэн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах үүргээ хэрэгжүүлж буй хэрэг юм.
- ☺ **“Хангах”** гэдэг нь гэрээг хүлээн зөвшөөрсөн улс хууль тогтоох, захиргааны, төсвийн, шүүхийн болон бусад арга замаар тэдгээр эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бий болгохыг хэлнэ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй сургууль, эмнэлэг байгуулах, мэдээллийг дохионы хэл, брайль үсгээр дамжуулан түгээх, төрийн албан хаагчдад дохионы хэл сургах зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхээ эдлэх боломж нөхцлийг бүрдүүлэх нь энэ үүргээ биелүүлж буй хэрэг юм.

Хүний эрхийн гэрээний дагуу олон улсын эрх зүйн субъектүүд дээр дурдсан үндсэн гурван үүргээс гадна хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих үүрэг хүлээдэг. Хөхиүлэн дэмжих гэдэг нь хүний эрх, эрх чөлөөний талаарх мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийнхээ мэдлэгийг нэмэгдүүлэхийг хэлэх бөгөөд гэрээгээр баталгаажуулсан эрхийг олон нийтэд таниулах, ойлгуулах нь төрийн бас нэгэн үүрэг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци ямар нэг шинэ эрх, эрх чөлөөний төрлийг бий болгож, баталгаажуулаагүй бөгөөд НҮБ-ын өмнөх гэрээ, конвенцийн заалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн олон улсын эрх

зүйн үүднээс системчилж, нэг мөр болгосон болохыг өмнө нь өгүүлсэн. Гэхдээ хүртээмж, хувийн нэгдмэл байдлыг хамгаалах, оршин суугаа орчиндоо бие даан амьдрах, хувийн хөдөлгөөн, сэргээлт, нөхөн сэргээлт зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхэд зайлшгүй хангагдах ёстой нөхцлүүдийг шинээр томъёолж, эдгээрийг бүрдүүлэхэд гэрээнд оролцогч улсаас авах арга хэмжээг заасан байдаг.

2000 онд дэлхийн 189 орны төр засгийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын дээд хэмжээний уулзалтаар “Мянганы тунхаглал”-ыг баталж, 2015 он гэхэд дараах зорилгуудад хүрэхийг санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн. Монгол Улсын Их Хурлын 2005 оны 25 дугаар тогтоолоор хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх зорилгыг нэмж, улсынхаа мянганы зорилтуудыг тодорхойлсон билээ.

Зорилго 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах

♿ Ядуурал хөгжлийн бэрхшээлийг, хөгжлийн бэрхшээл ядуу байдлыг бий болгодог бөгөөд ойролцоогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 85 орчим хувь нь ядуу, нэн ядуу амьдарч байна.

Зорилго 2: Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших

♿ Хөгжиж буй орнуудад амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 98 орчим хувь нь сургуульд суралцаж чадахгүй байгаа тухай тооцоо бий.

Зорилго 3: Хүйсийн тэгш байдлыг дэмжих, эмэгтэйчүүдийн эрхийг хангах

♿ Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь давхар алагчлалд өртөх эрсдэлтэй

нийгмийн эмзэг хэсэг билээ. Тэд нэг талаас эмэгтэй хүнийхээ хувьд нөгөө талаас хөгжлийн бэрхшээлийнхээ улмаас эрх нь зөрчигдөх эрсдэлтэй байдаг.

♿ Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөх нь эрүүл эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2-3 дахин их байдаг тухай олон улсын байгууллагын судалгаа бий. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн ч хуулийн байгууллагад хандах нь ховор байдаг.

Зорилго 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах

♿ Эрүүл хүүхдийн эндэгдлийг 20 хувь хүртэл бууруулж чадсан улс оронд ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эндэгдэл өндөр хувьтай байна.

Зорилго 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах

᠎ Жилд ойролцоогоор 20 орчим сая эмэгтэйчүүд жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй болж байна.

᠎ Эхийн төрөлтөөс өмнөх хэвийн бус үйл ажиллагаа нь хөгжиж буй орнуудад хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болох түгээмэл шалтгаан болдог ажээ.

Зорилго 6: Бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ/ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах

᠎ Өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл дутмагаас, эмнэлгийн үйлчилгээ хүртээмжгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аливаа өвчнөөр өвдөх нь элбэг байдаг.

Зорилго 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах

᠎ Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн тэнцвэртэй байдал алдагдах нь хүн хөгжлийн бэрхшээлтэй болох томоохон хүчин зүйл.

Зорилго 8: Хөгжлийн төлөө дэлхийн түншлэлийг хөгжүүлэх

᠎ Хурдаараа дэлхийг гайхашруулж байгаа мэдээллийн технологийн хөгжлөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хоцрогдсон хэвээр байна.

Зорилго 9: Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх

᠎ Монгол Улсын нийт хүн амын 8 орчим хувь болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ноцтой зөрчигдөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 70 гаруй хувь нь төрийн үйл хэрэг, нийгмийн амьдралд оролцож чадахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр мянганы зорилтуудад хүрэх боломжгүй...

Хэдийгээр манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрх, эрх чөлөөгөө эдлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгоход тодорхой ахиц гарч байгаа ч тэд эрх, эрх чөлөөгөө эдлэх нөхцлийг бий болгохуйц эрх зүйн хэм хэмжээ бүрэн төлөвшөөгүй, хууль тогтоомжийн хэрэгжүүлэх нөөц бололцоо хязгаарлагдмал, хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн үүднээс хандах олон нийтийн эерэг чиг хандлага төлөвшөөгүйгээс тэдгээр иргэдийн эрх, эрх чөлөө ноцтой зөрчигдсөөр байгаа юм.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах зорилгоор 35 орчим хууль тогтоомж, 20 гаруй үндэсний болон салбарын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг тодорхой шийдвэрлэхгүй орхигдуулсан, хэрэгжүүлэх байгууллага, механизмыг оновчтой тогтоож чадаагүйн улмаас эдгээр хууль тогтоомж, хөтөлбөрүүд зөвхөн “цаасан дээр” үлдэж, зориулагдсан хүндээ хүрч үр дүнгээ өгөхгүй байгааг холбогдох байгууллагууд анхааралдаа авах шаардлагатай байна.

Хэдийгээр НХХЯ-аас Монгол Улсын 115000 орчим хүн хөгжлийн бэрхшээлтэй гэх баримт байдаг боловч энэ нь бусад эх сурвалжуудын баримттай зөрчилддөг. Тэгэхээр нийт хүн амын 10 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байдаг гэх Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгааг үндэслэн Монгол Улсад 250000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдарч байна гэж үзвэл эдгээр эмзгийн эмзэг бүлэгт зүйн ёсоор тооцогдох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хангах, тэднийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцуулах тэгш хүртээмжтэй орчинг бий болгож, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх болон Монгол Улсад амьдарч буй хүн бүрт эрх, эрх чөлөөг бодитойгоор эдлүүлэх боломжийг олгоход онцгойлон анхаарал хандуулах, шийдвэртэй алхам хийх хэрэгтэй байгааг анхаарч Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улс соёрхон батлах нь нэн тэргүүнд шаардлагатай байна.



Т.ИХТАМИР

Хүний эрхийн Үндэсний Комиссын
референт

**ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ
ХҮЧИРХИЙЛЭЛ**

Хүний эрхийн үндсэн зарчмыг ноцтой зөрчиж буй нэг хэлбэр нь хүйсэнд суурилсан хүчирхийлэл түүний дотор эмэгтэйчүүдийг элдвээр хүчирхийлэх явдал юм.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь ялгаварлан гадуурхах, алагчлах хэлбэрийн тодорхойлолтод багтдаг бөгөөд энэ нь эмэгтэй хүнийх нь хувьд түүний эсрэг шууд чиглэсэн, бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх болон хүч хэрэглэх бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хязгаарлах зэрэг үйлдлүүдийг ойлгоно гэж тодорхойлжээ.¹

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийллээс гадна нийгэм, эдийн засгийн дарамт, мөлжлөг мөн уламжлалт зан үйлтэй холбоотой үйлдэгддэг хүчирхийллийн хэлбэрүүдтэй байх ба нийгмийн бүхий л салбарт илэрдэг байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хамгийн түгээмэл тохиолддог хэлбэр нь гэр бүлийн хүчирхийлэл юм. Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь өөрийн эрх мэдлээ тогтоох зорилгоор өөрийн давуу байдлаа ашиглан гэр бүлийн гишүүддээ бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн хор хохирол учруулж буй болон учруулж болзошгүй гэмт үйлдлүүд нь гэр бүлийн хүчирхийлэл бөгөөд энэ нь нийгэмд бодитой оршсоор байна. Энэ нь эмэгтэй хүн гэр бүлийн хүрээнд төрсөн цагаасаа өтлөх хүртлээ өөрийн амьдралын орчинд амсаж болох хүчирхийллийн хэлбэр юм.

¹ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах Явдлыг устгах Хорооны 1992 оны 11-р чуулганы ерөнхий Ерөнхий Зөвлөмж №19

Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл нь дараах байдлаар илэрнэ: Зодох, хамтран амьдрагчийн зүгээс хүчирхийлэх, инжтэй холбоотой хүчирхийлэл, эмэгтэйчүүд, нялхасын амь насыг бүрэлгэх, өрхийн эмэгтэй хүүхдийг хүчирхийлэх, эмэгтэйчүүдэд чиглэсэн зүй бус уламжлалт зан үйлтэй холбоотой хүчирхийлэл тухайлбал; эмэгтэйн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, эрт гэрлүүлэх, богтлох, хамтран амьдрагч бус хүмүүсийн зүгээс үйлдэгдэх хүчирхийлэл, гэрийн үйлчлэгчээр ажиллагсдыг хүчирхийлэх, мөлжлөгийн бусад хэлбэрүүдээр илэрдэг байна. Эдгээрээс хамгийн түгээмэл илэрдэг хэлбэр нь хамтран амьдрагчийн зүгээс үзүүлдэг хүчирхийлэл юм.

Дэлхийн 71 орныг хамруулж хийсэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гүнзгийрүүлсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн эсрэг хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа бэлгийн хүчирхийллийн амьдралын хугацаан дахь давтамж 6-59 хувь, бие махбодийн хүчирхийлэлийнх 10-50 хувийн хооронд байжээ.²

Эмэгтэйчүүдийн гэр бүлийн эсрэг хүчирхийлэл нь зөвхөн гэр бүл, тухайн улс орон, үндэстний хэмжээнд тулгамдаад байгаа асуудал төдийгүй хүний эрхийг дээдэлсэн энэ зуунд хүн төрөлхтөн дэлхий нийтээрээ үүний эсрэг нэгдэн тэмцэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Дэлхий дээр хүүхэд, эмэгтэйчүүд, охидын 3 эмэгтэй тутмын нэг нь зодуулдаг, 5 эмэгтэй тутмын нэг нь хүчингийн гэмт хэргийн хохирогч болдог тухай статистик тоо баримт байдаг.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мун 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох талаар удаан хугацааны компанит ажлыг зохион байгуулахыг гишүүн улс орнууддаа уриалсан билээ.

Олон улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах талаар хэд хэдэн тунхаглал, гэрээ, конвенцийг батлан гаргасан.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1, 2, 4, 7, 16, 17 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 8-р зүйлийн 8.2-т “Хэнийг ч бусдын эрхшээлд байлгаж болохгүй”, 17-зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасан нь хүн бүр түүний дотор эмэгтэйчүүд хүчирхийллээс ангид байх, хүчирхийлэлд

² Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа-2007 он

өртсөн тохиолдолд хуулиар хамгаалуулах эрхтэй болохыг баталгаажуулсан явдал юм.³

Манай улс Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид 1981 онд, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протоколд 2001 онд тус тус нэгдэн орсон.

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тунхаглал”, Эмэгтэйчүүдийн байдлын тухай 1995 оны дэлхийн 4 дүгээр бага хурлаас батлан гаргасан Бээжингийн тунхаглал зэрэг нь дээрх Олон улсын гэрээ, конвенцийн заалтыг нарийвчлан гүнзгийрүүлж ойлгох, цаашид практикт хэрэгжүүлэх арга зүйг тусгасан байдаг.

Эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэгчдэд хариуцлага хүлээлгэх, эмэгтэй хүн хуулийн өмнө тэгш эрх эдлэхийг баталгаажуулах нь олон улсын өмнө төрийн хүлээсэн үүрэг бөгөөд олон улсын гэрээ, конвенцийн үзэл санааг үндэсний хууль тогтоомждоо дараах байдлаар тусгасан байна.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Хүн амьд явах эрүүл мэндээ хамгаалуулах, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй” гэж заажээ. Мөн гэр бүлийн гишүүд тэгш эрхтэй байх, хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй болохыг заасан.

1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд “...гэрлэгсэд хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх нь тэдний үүрэг⁴” болохыг заасан. Мөн гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй буюу учирсан нь тогтоогдвол шүүх эвлэрүүлэх арга хэмжээг авахгүйгээр гэрлэлтийг цуцалж⁵ байхаар зохицуулсан.

Гэрлэгчид гэрлэлт цуцлах үедээ хүүхдийг хэний асрамжинд үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухай харилцан тохиролцоогүй бол шүүх эдгээр асуудлыг шийдвэрлэхдээ хүчирхийлэл үйлдсэн эсэхийг харгалзан үзэхээр⁶ хуульчилсан.

³ Монгол улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл ХЭҮК 2008 он нүүр-83

⁴ Гэр бүлийн тухай хууль 1999 он 10 дугаар зүйл

⁵ Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл

⁶ Гэр бүлийн тухай хууль 1999 он 14 дүгээр зүйл

2004 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийллийн хохирогчдын зөрчигдсөн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог⁷ тодорхой тусгасан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой болсон байна.

Хуулиар үүрэг хүлээсэн байгууллагууд гэр бүлийн хүчирхийллийн талаарх асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх судалгааны тоо баримтаас дурьдвал: Цагдаагийн байгууллагаас авсан арга хэмжээний 53.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг шууд хангахуйц арга хэмжээ болж чадаагүй байх ба авсан арга хэмжээний 27.3 хувь нь л хохирогчийг хамгаалах байр, эмнэлэгт хүргэсэн, хүчирхийлэл үйлдэгчийг баривчилсан, эрүүлжүүлсэн байна.⁸

2005 оны 6 сараас 2007 оны 6 сарын байдлаар хүчирхийлэлд өртөгч эмэгтэйчүүдийн шүүхэд хандсан байдлыг авч үзвэл шүүхээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хүчирхийлэл үйлдэгчид авах эрх хязгаарлах арга хэмжээний төрлүүдээс “Тусдаа амьдрахыг даалгах” арга хэмжээг хамгийн олон буюу 13 хүчирхийлэгчид оногдуулжээ.⁹ Гэвч энэхүү эрх хязгаарлах арга хэмжээ нь хохирогчийг зөвхөн хамгаалах байр, эсхүл нийгмийн асрамж, халамжийн байгууллага зэрэг тодорхой газруудад байгаа тохиолдолд л аюулгүй байдлыг хангахаас биш бусад тохиолдлуудад энэ хамгаалалт нь үр дүнтэй биш юм. Иймээс хүчирхийлэл үйлдэгчийн эрх хязгаарлах арга хэмжээ нь хохирогчийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй байгаа ба нөгөөтэйгүүр хуульд хүчирхийлэл үйлдэгчид авах эрх хязгаарлах арга хэмжээний хугацааг зааж өгөөгүй нь учир дутагдалтай юм.

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, хүчирхийллийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэгдмэл зохион байгуулалттайгаар цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас 2007 оны 9 дүгээр сард батлан гаргасан.

Судалгаагаар манай улсад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын дийлэнх нь 18-49 насны эмэгтэйчүүд байна. 3 эмэгтэйн 1 нь хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртдөг ба эдгээр хүчирхийллийн хэлбэрүүд дотроос 10 эмэгтэйн 1 нь зодуулдаг¹⁰ гэсэн байна.

⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 он 1 дүгээр зүйл

⁸ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдал ХЭҮТ, Дэлхийн Зөн Монгол хүүхэд хамгаалал хөтөлбөрийн хамтарсан судалгаа 16 2007 он нүүр 7

⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдал ХЭҮТ Дэлхийн Зөн Монгол хүүхэд хамгаалал хөтөлбөрийн хамтарсан судалгаа 16 2007 он нүүр 8

¹⁰ Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, ХЭҮТ хамтран 5000 хүнийг хамарсан судалгаа 1995, МУИС-ын Хүн ам зүйн сургалт судалгааны төв, ХЭҮТ хамтран 3000 хүнийг хамарсан судалгаа 1998

Хохирогч эмэгтэйчүүдийн дийлэнх нь хөнгөн гэмтэл авдаг нь гэр бүлийн хүчирхийлэлийн үр дагавар ялимгүй мэт сэтгэгдлийг төрүүлдэг ч уг гэмтлийг удаа дараа авч байдгаас хохирогч сэтгэцийн эмгэг байдалд амархан ордог байна.¹¹

Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд “гэр бүлийн хүчирхийлэл гэж” хүчирхийлэл үйлдэгч нь гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэл¹² байхаар заажээ. Энэхүү үйлдлүүдэд “эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй” бол гэж хязгаарлалт тогтоосон нь гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үзэхгүй байгааг харуулж байна. Иймд энэ асуудлыг хууль тогтоогчид анхаарах нь зүйтэй юм.

Зодох, доромжлох, гүтгэх, заналхийлэх, танхайрах, хүнд, хүндэвтэр гэмтэл учруулах, тарчлаах, амиа хорлоход хүргэх, амь биед аюултай нөхцөлд орхих, алах, хүчиндэх гэх мэт гэмт үйлдлүүдэд Эрүүгийн хуулиар ял шийтгэл хүлээлгэдэг боловч гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг хүчирхийллийн улмаас хохирогчийн биед ямар нэгэн гэмтэл учраагүй бол гэр бүлийн хоорондын маргаан гэдэг үндэслэлээр гэмт хэрэгт тооцохгүй байх, нөгөөтэйгүүр хүчирхийллийн хохирогчид хөнгөн гэмтэл учирсан бол Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт зааснаар бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулсан гэдэг зүйл заалтаар хүчирхийлэгчид эрүүгийн хэрэг үүсгэн шалгадаг ч хүчирхийлэгч нь хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож байна.

Иймд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хохирогчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх үүднээс Эрүүгийн хуульд “гэр бүлдээ хүчирхийлэл үйлдэх” гэсэн зүйл заалтыг нэмж оруулах шаардлага гарч байна.

¹¹ Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн Монгол дахь байдал 2007он нүүр 15

¹² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 он 5 дугаар зүйл



Ч.ОТГОНЧУЛУУН

Хүний эрхийн Үндэсний Комиссын
ахлах референт

ОЛОН НИЙТИЙН ҮЙМЭЭН САМУУНЫ ҮЕД АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛУУД

Иргэний улс төрийн эрх нь иргэдэд улс орны ба улс төрийн амьдралд оролцох боломжийг олгодог бөгөөд төр, нийгмийн үйл хэргийг удирдахад оролцох эрх буюу сонгох, сонгогдох эрх, эвлэлдэн нэгдэх эрх, жагсаал цуглаан хийх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхүүд хамаарагдана.

Эвлэлдэн нэгдэх эрх нь иргэний улс төрийн эрхийн нэг юм. Энэ эрхийн нэрнээс үзэхэд холбоо, нийгэмлэг зэрэг төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдэх тэдгээрийн эрх тэгш байдлын тухай утга санааг агуулсан байна.

Хуулийн шаардлагын хүрээнд аливаа холбоог иргэд байгуулах эрхтэй. Нууц нийгэмлэг, цэрэгжсэн байгууллага, нийгмийн эсрэг зорилготой нэгдэл байгуулахыг хориглох байдлаар эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлах тухай заалт аливаа улсуудын хуульд ямагт тогтоосон байдаг.

Эвлэлдэн нэгдэх эрх нь үнэмлэхүй эрх /жам ёсны эрх/ биш бөгөөд онцгой буюу дайны байдал тогтоосон тохиолдолд хязгаарлаж болно. Иргэн үзэл бодлын үүднээс нам болон олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй байна.

Эвлэлдэн нэгдэх эрхийн нэг арга хэлбэр бол жагсаал цуглаан хийх эрх юм. Үндсэн хуульд “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаах хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно”¹ гэж заасан байдаг.

¹ Үндсэн хуулийн 16 зүйлийн 16

“Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шудрага шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос зохих хязгаарлалтад л захирагдана”² гэж заасан нь хүн бүр эвлэлдэн нэгдэж, жагсаал, цуглаан хийх эрхтэй боловч энэ нь хуулийн дагуу байх ёстойг илэрхийлж байна.

Хуулиар “Хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр гадуурхахыг хориглоно”³. Иймд ямар нэг нийтийг хамарсан үймээн самуун гаргаагүй, тайван бус замаар хийж байгаа жагсаал цуглааны үеэр цагдаагийн буюу нийгмийн хэв журам сахиулах байгууллага хүч хэрэглэх эрхгүй.

Зөвхөн байдлыг ажиглан, хамгаалалтын бэлэн байдалд байх үүрэгтэй. Мөн жагсаал цуглаан хийх тухай хуульд хууль бус жагсаал цуглааны талаар заасан байна.

Хууль бус жагсаал цуглааны үр дүн нь зарим тохиолдолд нийтийн эмх замбараагүй байдлыг бий болгодог. МУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангид “Нийтийн эмх замбараагүй байдал бий болгох”⁴ гэсэн зүйлд энэхүү гэмт хэргийн объектив тал нь түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх замаар нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан, өдөөн турхирсанаар илэрдэг.

Нийтийн эмх замбараагүй байдал нь олон улсын шинжтэй зэвсэгт мөргөлдөөн биш хэдий ч, тодорхой аюул, болон үргэлжлэх хугацааны шинж чанартай бөгөөд хүчирхийлэлийн үйлдлүүдийг агуулж байдаг. Улс орны дотор сөргөлдөөн бүхий нөхцөл байдал бий болгодог. Энэхүү байдал янз бүрийн хэлбэрээр эмх замбараагүй бослого үймээн самуун, янз бүрийн зохион байгуулалттай бүлэглэлүүд болон эрх баригч хүчний хоорондын тэмцэл хүртэлх бүх замаар илэрч гардаг байна.

Нийтийн эмх замбараагүй байдлын улмаас олон тооны хохирогч бий болдог тэдэнд хүмүүнлэгийн наад захын тусламжийн жишиг хэмжээг тогтоох шаардлагатай болсон байдаг.

Нийгмийн хэв журам сахиулах албан тушаалтан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон Улс Төрийн эрхийн Олон улсын Пакт, Үндэсний хууль тогтоомжоор

² Хүний эрхийн түгээмэл тунхаглал 29 зүйлийн 1

³ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 6.1-р зүйлд

⁴ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 179 зүйл

баталгаажсан хүний амьд авах эрх, аюулгүй, халдашгүй байх эрхийг хамгаалахад онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг.

Цагдаагийн байгууллага олон нийтийг хамарсан үймээн самууны үед үймээн самууныг зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэм буруутанг баривчлах, бусад иргэдийн эрхийг хамгаалах үүднээс хуулиар зөвшөөрөгдсөн тусгай хэрэгсэлийг хэрэглэх эрх бүхий байгууллага юм.

Цагдаагийн болон хүчний байгууллага нь хүмүүнлэгийн зарчмын үндсэндээр үйл ажиллагаа явуулах ёстой бөгөөд олон улсын хүний эрхийн Биллээр баталгаажсан хүний үнэмлэхүй эрхийг хөндөхгүйгээр дараах стандартуудад анхаарч ажиллах шаардлагатай байдаг.

Нийгмийн эмх замбараагүй байдал

Хүний эрхийн стандартууд

- Хэв журмыг сахиулахад заавал хүний эрхийг дээдлэх ёстой
- Хэв журмыг сахиулахад ялгаварлан гадуурхалт байж болохгүй
- Хуулиар тогтоосон гарцаагүй байдалд хүний эрхийг хөндөж болно

Нийгмийн хэв журмыг сахиулах ажиллагаа нь зөвхөн бусдын эрх чөлөө, нийгмийн аюулгүй байдал, ёс суртахууныг хамгаалахын төлөө байх ёстой.

Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс урьдчилан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй. Аливаа хүний эрхийг хязгаарлах үйл ажиллагаа нь ардчилсан ёсонд нийцэх ёстой.

“Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй.”⁵

Хүний амьд явах эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, боолын хөдөлмөр эрхлэхгүй байх эрх, халдашгүй байх эрх, үзэл бодол чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх ёс шүтэх эрхийг нь ямарч байдалд хязгаарлаж болохгүй гэж олон улсын баримт бичгүүдэд эдгээр эрхүүдийг ямарч тохиолдолд хязгаарлаж болохгүйг заасан байдаг.

⁵ ИУЭОУП-ын 21 дүгээр зүйлд

Хүч хэрэглэх үйл ажиллагаа эхлэхээс өмнө хүч хэрэглэхгүй байх талаас нь бүх арга хэмжээг авах хэрэгтэй. Хүч хэрэглэх үйл ажиллагааг зөвхөн гарцаагүй байдалд хэрэглэнэ. Хүч хэрэглэх үйл ажиллагаа нь нийгмийн хэв журмыг сахиулахтай холбоотой хуультай нийцсэн байх ёстой. Тэгвэл нийгмийн хэв журмыг сахих үйл ажиллагаа нь хуулийн зорилгын дагуу байх ёстой.

Гарз, хохиролыг аль болох бага учруулах арга хэмжээг авах, хүч хэрэглэх үйл ажиллагааг цар хүрээгээр нь ангилах ёстой.

Хуулиар эрх олгогдоогүй байгууллага иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхэнд халдаж болохгүй.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг ямарч тохиолдолд хязгаарлаж болохгүй талаар ИУЭОУП-д “амьд явах, шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхүүдийг ямарч тохиодолд хязгаарлаж болохгүй” гэж заасан байдаг.

Хууль хяналтын байгууллагын хараат бус байдлыг хангах ёстой. Шархадсан, гэмтсэн хүмүүст яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх ёстой.

Онцгой байдал

Хүний эрхийн стандартууд

- Онцгой байдлыг зөвхөн хуулийн дагуу зарлах ёстой
- Онцгой байдлыг зөвхөн үндэстэн мөхөх аюул тулгарсан үед зарладаг
- Арга хэмжээ авахаас өмнө онцгой байдлыг албан ёсоор зарлах ёстой
- Онцгой байдал зарласан нь олон улсын баримт бичгүүдэд нийцэж байх ёстой
- Онцгой байдлын үед гарал үүсэл, арьсны үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхаж болохгүй
- Хүний амьд явах эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, боолын хөдөлмөр эрхлэхгүй байх эрх, халдашгүй байх эрх, үзэл бодол чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх ёс шүтэх эрхийг нь ямарч байдалд хязгаарлаж болохгүй.
- Хэнийг ч гэмт хэрэг үйлдээгүй байхад онцгой байдлыг ашиглан гэмт хэрэгтэнд тооцож болохгүй

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутанд зөвхөн хуулиар заасан ялыг оногдуулах ёстой

Зэвсэгт мөргөлдөөн

Хүний эрхийн стандартууд

- Зэвсэгт мөргөлдөөн болон түрэмгийллийн үед цагдаагийн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа нь дайны ажиллагаанд тооцогдохгүй

- Бүх зэвсэгт мөргөлдөөний үед хүний эрхийн асуудал хөндөгддөг
- Хүний эрхийн зарчмыг бүх нөхцөл байдалд баримтлах ёстой
- Зэвсэгт мөрдөлдөөнд оролцоогүй эсвэл оролцож байхдаа шархадсан өвдсөн, олзлогдсон хүмүүсийг хүндэтгэн, хамгаалах ёстой
- Зэвсэгт мөргөлдөөний улмаас хохирсон хүмүүст тусламж үзүүлэх ёстой
- Шархадсан, өвдсөн, иргэдээр эмнэлгийн ажилтнууд, эмнэлэнийн бүтээгдэхүүний туршилт хийхийг хориглоно
- Олон улсын баримт бичгүүдэд заасан эрхээсээ хэнийг ч татгалзахыг шаардаж болохгүй
- Хүн бүр хүссэн цагтаа хүний эрхийн асуудлаар холбогдох байгууллагад хандах эрхтэй / хүний эрхийн Үндэсний байгууллага, Улаан Загалмайн Нийгэмлэг, үймээн самуун болоогүй улс орнуудын эрх баригчид/

Цагдаагийн байгууллагын ажилтнууд олон нийтийн эмх замбараагүй байдлын үед дараах зүйлүүдэд анхаарах ёстой. Үүнд:

- Иргэдийн тайван жагсаал цуглаан хийх эрхийг цагдаагийн байгууллага хүндэтгэх, хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулах ёстой
- Цагдаагийн байгууллага нийгэмд байгаа иргэний нийгмийн бүлэг болон хөдөлгөөнүүд, эрх баригчдын хоорондын харилцааг судлан, байнга хяналт тавьж төлөвлөгөө боловсруулж ажилладаг байх шаардлагатай
- Хууль бус жагсаал цуглааны талаар байнга мэдээлэлтэй байх
- Хууль бус жагсаал цуглаан боловч нийгэмд аюулгүй, тайван жагсаал хэлбэрээр явагдаж байгаа тохиолдолд тэвчээртэй хандах ёстой. Ингэснээр нөхцөл байдлыг дэврээхгүй байх нэг арга зам болно
- Жагсан цуглаж байгаа хүмүүсээс уг үйл ажиллагааг удирдаж, төлөөлж байгаа хүнтэй холбоо тогтоохыг оролдох хэрэгтэй
- Жагсан цуглаж байгаа хүмүүстэй харьцахдаа хэсэг бүлэг хүмүүс биш хувь хүн гэдэг байдлаар харьцах хэрэгтэй
- Шалтгаангүй өдөөн хатгах зэрэг арга хэмжээнээс зайлсхийх хэрэгтэй
- Үймээн самууны үед аль болох бага хүч хэрэглэх төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, биеэ хамгаалах, хамгаалах тусгай хэрэгсэл, номхотгох зэвсэг, галт зэвсэг хэрэглэх, жагсаал цуглаан үймээн самууны үед олон нийтийн үйлдлийг хянаж зохицуулах, мөн түүнчлэн өөрийгөө хэрхэн стерессээс гаргах сургалтуудад хамрагдаж идэвхтэй суралцах хэрэгтэй. /Аливаа зэвсэг, хэрэгсэлийг заавал заавар, журмын дагуу хэрэглэх хэрэгтэй/
- Бамбай, сум нэвтрэхгүй хантааз, хамгаалалтын дуулга зэрэг амь насанд аюулгүй хэрэгсэлүүдийг ашиглаж сурах

- Амь насанд аюулгүй аливаа хэрэгслүүдийн ялган хэрэглэх /хүч хэрэглэх болон галт зэвсэг хэрэглэх нарийн төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй, энэ нь аль болох бага хохирол учруулахаар байх хэрэгтэй./
- Гарцаагүй тохиолдлоос бусад тохиолдолд хүний биед гэмтэл учруулах галт зэвсэг хэрэглэхийг хориглох
- Хэрхэн үймээн самууныг зогсоох талаар үечилсэн төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй

Цагдаагийн байгууллагын ажилтнууд

- Зэвсэгт мөргөлдөөний үед хүний эрхийг хангах, хамгаалах, хөндөхгүй байх талаар бэлтгэх
- Иргэдэд анхан шатны тусламж үзүүлэхэд бэлтгэх
- Үймээн самуун, мөргөлдөөны үед эмх замбаараагүй байдлыг таслан зогсоох
- Эмнэлэг, гал команд, цэрэг, иргэний байгууллагуудтай нягт холбоотой ажиллах
- Эмэгтэйчүүд, хүүхдүүд, шархадсан хүмүүст онцгой анхаарал хандуулах хэрэгтэй

Дараах ажиллагааг бүх тохиолдолд хориглоно. Үүнд:

- аллага хийх
- эрүү шүүлт явуулах
- бие мах бодийн шийтгэл үзүүлэх
- гарз хохирол учруулах
- хүнийг гутаан доромжлох, хүчиндэх
- хүнийг барьцаалах
- бүлэглэн шийтгэх
- албан ёсы шүүх ажиллагаа явуулахгүйгээр цаазаар авах
- хүнлэг бус хэрцгийгээр харьцах

Дээрх олон улсын стандартуудыг цагдаагийн байгууллага нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагаандаа баримталан ажиллаж байх үүрэгтэй байна.



Б.ДОЛГИОН

Хүний эрхийн Үндэсний Комиссын
референт

ЦАГААЧ АЖИЛЧДЫН ЭРХ

Одоогоос 18 жилийн тэртээ 1990 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий ассамблей бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцийг батлан гаргаж байжээ.

Конвенци нь цагаач ажилтны эрхийг хүлээн зөвшөөрүүлэх, уг эрхийг хамгаалах, хүндэтгэн үзэх талаар тавьж буй хүчин чармайлтын түүхэнд шинэ хуудас нээсэн юм. Энэ нь заавал биелэгдэх шинжтэй гэрээ конвенци, НҮБ-ын хүний эрхийн талаархи судалгаа, шинжээчдийн хурлаас гаргасан дүгнэлт, зөвлөмж болон сүүлийн хорь гаруй жилд НҮБ-ын эрхлэх байгууллагуудаас цагаач ажилтны эрхийн асуудлаар хийсэн хэлэлцүүлэг, баталсан тогтоол зэрэгт үндэслэн боловсруулсан олон улсын цогц гэрээ билээ.

Уг конвенци нь олон улсын хүний эрхийн бусад гэрээ конвенцуудын адил улс тус бүрийн хууль тогтоомж, шүүхийн болон захиргааны хэргийг байцаан шийтгэх ажиллагаанд загвар болох хэм хэмжээг тогтоосон. Конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсон улсуудын засгийн газар шаардлагатай арга хэмжээг авах замаар түүний заалтуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Мөн эрх нь зөрчигдсөн цагаач ажилтанд шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах нөхцлийг бүрдүүлэх учиртай.

“Цагаач ажилтан” гэдэг нь гадаад улс оронд цалин хөлстэй ажил эрхлэх гэж байгаа буюу одоо эрхэлж байгаа, эсвэл тийм ажил хийж байсан хүнийг хэлнэ.

Цагаач ажилтан нь сүүлийн үед гарч ирсэн ойлголт биш бөгөөд хүмүүс хөдөлмөр эрхэлснийхээ төлөө цалин хөлс авах болсон тэр цагаас эхлэн ажил хайн эх орноо орхин явах болсон. Харин одоо цагийн гол онцлог бол түүхийн аль ч үед байгаагүй олон цагаач

ажилтан бий болсонд байгаа юм. Сая саяраа хүмүүс гадаад улсад ирж, амьдран аж амьдралаа залгуулахаар ажил хайж, бүх төрлийн ажлуудаас хийж байна. Дэлхий дээр ямар нэгэн хэмжээний цагаач ажилтангүй нэг ч тив, нэг ч бүс нутаг байхгүй билээ.

Ядуурал, нөгөө талаас өөрийгөө болон гэр бүлээ хангалттай тэжээж чадахуйц цалин хөлс авч чадахгүй байх нь хүмүүсийг нэг улсаас нөгөө улс руу ажил хайн явах нэгэн гол шалтгаан болж байдаг. Энэ нь ядуу орноос баян орон руу цагаачлан очигчдын гол шинж чанар болохоос гадна нөгөө талаар ядуурал нь аль нэг хөгжиж байгаа улсаас ажил олох боломж арай дээр санагдаж байгаа өөр нэг хөгжиж буй улс руу шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлдэг.

Хүмүүс гадаад руу цагаачлах өөр шалтгаанууд ч байдаг. Дайн, иргэний мөргөлдөөн, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хэл яриа болон улс төрийн үзэл бодлоосоо болж аюулд өртөх буюу мөрдөж мөшгигдөх зэрэг нь цагаач ажилтны тоог нэмэгдүүлэх хүчин зүйл болж байдаг.

Зарим улс өөрийн иргэдийг гадаадад ажиллуулахыг дэмждэг бол нөгөө зарим нь гадаадын ажилтныг олноор нь авч ажиллуулдаг. Зарим тохиолдолд, цагаачдын хөдөлмөр эрхлэлтийн талаар хоёр талын гэрээ хэлэлцээр байгуулагддаг байна.

Манай улс нь өөрийн иргэдийг гадаадад ажиллуулахыг дэмждэг улсад багтах ба ихэнхидээ БНСУ, АНУ, Япон, Тайваньд ажиллах хүч гаргаж байна.

БНСУ-д ажиллаж байгаа Монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт, тэдний эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт өгч, нөхцөл байдлыг сайжруулахад чиглэгдсэн санал, зөвлөмж гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх зорилгоор “БНСУ-д ажиллаж буй Монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт” судалгааны ажлыг 2007 онд Хүний эрхийн Үндэсний Комисс хийсэн юм.

Манай улсаас авч ажиллах хүчний тоогоороо БНСУ тэргүүлдэг бөгөөд өнөөгийн байдлаар нийт 28720 орчим Монгол иргэд ажиллаж амьдарч байна. Тэдний дөнгөж 60 хувь нь л албан ёсны гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа юм.

Нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн тогтолцоо, эрх зүй, хэл, ёс заншил, сэтгэл зүйн огт өөр нөхцөлд ажиллаж буй монгол иргэдэд орчиндоо дасан зохицох, хөгжих, өөрийн эрх ашиг, эрүүл мэндээ хамгаалах талын мэдээлэл дутагдалтай байдаг нь судалгааны дүнгээс харагдсан. Монгол иргэд хөдөлмөрийн хөлсөө авч чадахгүй байх, үйлдвэрийн осолд орох, гэмтэх бэртэх, эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах зэргээр эрх нь зөрчигдөх тохиолдол цөөнгүй гардаг байна.

Ер нь цагаач ажилтан нь гэрээгээр буюу бусад албан ёсны тохиролцооны дагуу ажиллаж байгаа, эсвэл өөрсдийн санаачилгаар хөдөлмөр эрхлэж байгаагаас хамаарахгүйгээр очих гэж буй орныхоо хэл, соёл, эрх зүйн болон нийгэм, эдийн засгийн тогтолцооны талаар наад захын ойлголтыг олж авсан байх шаардлагатай. Мөн тэнд очоод авах цалин хөлс, ажлын нөхцөл болон амьдралын ерөнхий нөхцөл байдлын талаар урьдчилан мэдсэн байх учиртай. Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенцийн 33 дугаар зүйлд заасан ёсоор оролцогч улсууд энэхүү конвенциор олгогдсон эрх болон хүлээн авагч улсад дагаж мөрддөг захиргааны болон бусад дүрэм журмын талаархи мэдээллийг цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдэд хүсэлтийнх нь дагуу үнэ төлбөргүйгээр, хэрэв боломжтой бол тэдний ойлгодог хэлээр өгөх талаар холбогдох арга хэмжээг авахыг үүрэг болгосон. Мөн түүнчлэн Конвенцийн 37 дугаар зүйлд цагаач ажилтан болон тэдний гэр бүлийн гишүүд “хүлээн авагч улс руу явахаас өмнө эсхүл цаад зах нь тус улс руу нэвтрэхээс өмнө” тийнхүү нэвтрэхэд шаардагдах бүхий л нөхцөл шаардлага болон “хүлээн авагч улсад биелүүлэх ёстой шаардлагууд ба тэдгээр шаардлага өөрчлөгдсөн үед хандах ёстой байгууллагын талаар” мэдээлэл авах эрхтэй хэмээн заасан. Гэтэл судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 88.3 хувьд нь харилцааны бэрхшээл, 71.3 хувьд нь мэдээллийн дутмаг байдал, 75.1 хувьд нь цалингаа авах хүртлээ санхүүгийн хүндрэлтэй тулгардаг бол 64.6 хувь нь сэтгэл санааны багагүй дарамтанд орж, 50.9 хувьд нь хоол унд тохирохгүй, цаг агаарт нь дасахгүй байх, 34.2 хувьд нь орон байрны асуудал тулгарсан байна.

БНСУ-д ажиллаж буй Монгол иргэдийн хүний эрхийн талаарх мэдлэг ойлголт хангалтгүй, судалгаанд оролцогчдын дөнгөж 4.8 хувь нь БНСУ-ын хөдөлмөрийн хууль, 7.0 хувь нь ажил олгогчтой байгуулсан гэрээний агуулгыг хангалттай сайн мэдэж байжээ.

Харин АНУ-д Монголын эхний цагаач хүмүүс 1949 оноос эхэлж ирсэн гэж үздэг ба тэд өөрсдийн нутагтаа үзэл бодлоороо шахагдсан хүмүүс байсан байна. Үүнээс хойш 1990 онд Монголд ардчилсан засаглал бүрдсэний дараагаар 2000 он хүртэл Америк дах Монгол цагаачдын тоо эрс нэмэгдсэн байна.

Америк дахь Монголчууд	
Нийт хүний тоо	15000-18000
Бүс нутгаар хүнийг хуваасан тоо	
Калифорн	3000
Виржиниа	2600
Колорадо	2000
Иллинойс	700
Хэл	Монгол, Англи
Шашин	Буддын, Христ

Цагаачлалын асуудлыг албан ёсны ажил олгох байгууллага хариуцан ажиллах нь ажилд элсүүлэх, хуваарилах асуудлыг хувийн агентлагуудын мэдэлд байлгаснаас илүүтэйгээр цагаачид гадаадад ажиллаж, амьдрахад шаардлагатай наад захын бэлтгэлээ сайн хангах боломжтой байдаг.

Харамсалтай нь, сая сая цагаач ажилтан гадаад оронд очоод хэрхэн ажиллаж, амьдрах талаар маш муу мэдээлэлтэй, муу бэлтгэгдсэн байдаг. Тэдний олонхи нь олон улсын гэрээ хэлэлцээр болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар ямар ч ойлголтгүй байдаг байна.

Цагаач ажилтан гэдэг шалтгаанаа тэд амьдарч, ажиллаж буй газрынхаа оршин суугчдын сэжиглэл, дайсагналын бай болдог. Ихэнхи тохиолдолд тэд ядуу байдаг учраас хүлээн авагч улсын нийгмийн хамгийн гадуурхагдсан давхаргынхантай адилхан эдийн засаг, нийгэм, соёлын бэрхшээлүүдтэй тулгардаг байна.

Хөдөлмөрийн салбарт цагаач ажилтныг ялгаварлан гадуурхах янз бүрийн хэлбэр байдаг. Тухайлбал, цагаачдад нээлттэй буюу хаалттай байдаг ажлын төрөл хэлбэрүүд, мэргэжлийн боловсрол эзэмшихэд учирдаг саад тотгор зэргийг дурдаж болно. Ажлын нөхцлийн талаар тухайн улсын харъяат иргэд болон цагаач иргэдэд ихэвчлэн ялгаатай стандарт үйлчилдэг бөгөөд хөдөлмөрийн гэрээ ч цагаачдад зарим нэг давуу тал олгодоггүй.

Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенцийн 25 дугаар зүйлийн 1-д “цагаач ажилтан нь цалин хөлсний болон ажлын байрны бусад нөхцөл, хөдөлмөрийн нөхцлийн хувьд ажил олгогч улсын харъяат иргэдэд үйлчилдгээс дутуугүй таатай нөхцлийг эдлэнэ” хэмээн заасан. 25 дугаар зүйлийн 3-т цагаач ажилтны дээрх эрхийг хасаж болохгүйг баталгаажуулсан.

Цагаачдыг тодорхой төрлийн ажлыг албадан хийлгэх буюу тусгай бүс нутагт албадан байлгах, түүнчлэн ижил төрлийн ажилд тэгш бус цалин хөлс, зэрэглэл тогтоосон хууль зүйн болон захиргааны журмын талаар жишээ баримт байсаар байна. Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой журамд цагаач ажилтныг хамруулахгүй, тэднийг Үйлдвэрчний Эвлэлийн үйл ажиллагаанд оролцох эрхийг нь зөрчих тохиолдол гардаг.

Түгээмэл тархсан ойлголт бол цагаачдыг нэмэлт ажлын хүч гэж үзэх, тухайн улсын иргэдийн сонирхлыг бага татдаг ажлыг тэдэнд өгөх явдал юм.

Цагаач ажилтныг хууль бусаар элсүүлж, тээвэрлэж, ажиллуулж байгаа нөхцөлд хүний эрх, үндсэн эрх чөлөө нь хамгийн ихээр зөрчигдөх аюултай тулгардаг. Хөгжиж буй олон орон дахь нийтийг хамарсан ядуурал, ажилгүйдэл, ажлын байрны хомсдол зэрэг нь ашиг хонжоо хайсан ажил олгогчид, хувь зуучлагчдад аятайхан хөрс болж байдаг бөгөөд тэр ч байтугай зарим тохиолдолд ажилтныг нууцаар гаргах үйл ажиллагаа гэмт хэргийн шинжтэй байдаг.

Албан ёсны статусгүй хууль бус цагаачид мөлжлөгийн бай болдог. Тэд ажил олгогчдын тааллаар байж, ямар ч хамаагүй ажил, амьдралын болон ажлын нөхцлийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрнэ. Тэр ч бүү хэл, цагаач ажилтны нөхцөл байдал боолчлол буюу албадан хөдөлмөртэй ижил байх нь ч бий. Хууль бус цагаачид баригдах, хөөгдөхөөс айдаг учраас барагтай бол эрх зүйн туслалцаа авч чаддаггүй бөгөөд олон оронд тэдний асуудлаар гарсан захиргааны шүүхийн шийдвэрийг давж заалдах боломжгүй байдаг.

БНСУ-д ажиллаж буй Монголчуудын хувьд ч хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй ажилчид илүү хүнд нөхцөлд ажилладаг байна. Орон байр, хөдөлмөрийн нөхцөл зэргээрээ тэд хууль ёсоор амьдран суугчдаас хүнд нөхцөлд байдаг ба ажил олгогчийн зүгээс байнгийн дарамт шахалт үзүүлдэг ажээ.

Эдийн засгийн уналтын үед гадаад ажилтныг хууль ёсоор цагаачлах явдлыг хязгаарлах нь түгээмэл байдаг. Хууль ёсоор орж ирэх явдлыг ийнхүү хязгаарлах нь зөвхөн түр хугацаанд буюу хязгаарлагдмал үр нөлөө үзүүлдэг бөгөөд цагаачлахыг хүсэгчдийн урсгалыг хууль бус сувгууд руу чиглүүлдэг.

Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенцийн 68 дугаар зүйлд заасан ёсоор оролцогч улсууд “хууль бус буюу далд шилжилт хөдөлгөөн болон цагаач ажилтны хууль бус хөдөлмөр эрхлэлтээс урьдчилан сэргийлэх, устгах асуудлаар хамтран ажиллахыг” даалгасан. Тодруулбал, оролцогч улсууд цагаачлалын асуудлаар буруу ташаа мэдээлэл тараахын эсрэг, хууль бус ба далд цагаачлалыг илрүүлж, устгах, хууль бус, далд цагаачлалыг зохион байгуулж, хэрэгжүүлж,

түүнд туслалцаа үзүүлж байгаа болон хууль бусаар амьдарч байгаа цагаач ажилтны эсрэг хүч, заналхийлэл, сүрдүүлэлт хэрэглэж буй эсхүл тийм ажилтныг ажиллуулж байгаа хувь хүн, бүлэг буюу байгууллагад үр нөлөөтэй шийтгэл оногдуулах талаар зохих арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

Гэсэн хэдий боловч, цагаачлалын үндсэн шалтгаан болсон эдийн засгийн буурай хөгжил, ажлын байрны хомсдлын эсрэг тэмцэхгүйгээр ажиллах хүчний гадаад руу чиглэсэн далд шилжилтийг зогсоох аргагүй билээ. Тийм ч учраас, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, аж үйлдвэржсэн орнууд ба хөгжиж байгаа бүс нутгийн хоорондын ялгааг багасгах арга хэмжээ авах нь уг асуудлыг шийдвэрлэхэд туслах нэгэн арга зам мөн.

Олон улсын түвшинд хууль бус цагаачлалтай холбоотой асуудлын гурван талыг онцлон авч үздэг. Тодруулбал, хууль бус цагаачийг нэг талаас цагаачлалын хуулийг зөрчигч, нөгөө талаас жирийн ажилтан эсвэл хүн гэдэг талаас нь авч үздэг. Эдгээрийн аль нь ч байлаа гэсэн өөрийн гэсэн хууль эрх зүйн үр дагавартай бөгөөд тэдгээрийг тухайн ажилтны эрхэд хор хохирол учруулахуйц байдлаар хольж сольж ойлгож болохгүй.

Цагаач ажилтны эрхийн асуудал нь одоо цагт хүний эрхийн гол анхаарал татсан асуудлуудын нэг яах аргагүй болоод байна.

2008 оны 6 дугаар сарын байдлаар гэхэд Монгол Улсад түр хугацаагаар оршин суугч 60 орны 7570 хүн, хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч 47 орны 989 хүн, албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч 87 орны 25651 хүн, байнга оршин суугч 59 орны 1221 хүн, цагаач 13 орны 2401 хүн, харъяалалгүй 70 хүн байна. Нийт 106 орны 37902 гадаадын болон харъяалалгүй хүмүүс байсан. Өөрийн улсын иргэдийг гадаадад гаргахаас гадна гадаадаас ажиллах хүч авч эхэлсэн нь манай улсын хувьд цагаач ажилтны тал дээр анхаарал хандуулах зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна.

Ашигласан ном, материал

Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенц

БНСУ-д ажиллаж буй Монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт /ХЭҮК/

Цагаач ажилтны эрх – Мэргэжлийн гарын авлага /НҮБ-ын ХЭДКГ/

Монголын цагаач ажилчид - Wikipedia



М.ЦОЛМОН

Хүний эрхийн Үндэсний Комиссын
референт

ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Өнөөдөр хүний эрүүл мэндээ хамгаалуулах асуудал дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг нэг болж уг асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн анхаарал тавих боллоо.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрх гэдэг ойлголтийг үндэстнүүд Үндсэн хуулиараа баталгаажуулсан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн арванхоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 6-д: “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” хэмээжээ.

Хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг олон улсын гэрээ, конвенциудад тусган түүнийг хэрэгжүүлэхэд улс орон бүр хүчин чармайлт гарган ажиллахыг үүрэг болгосон байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25.1 дүгээр зүйлд: “Хүн бүр өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл байх зайлшгүй шаардлагатай хоол хүнс, хувцас, орон байртай байх, эмнэлгийн тусламж болон нийгмийн халамж хүртэх эрхтэй” хэмээн заажээ.

Энэ эрхийг хамгийн өргөн утгатай тусгасан олон улсын хүний эрхийн баримт бичиг нь Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн олон улсын пакт юм. Пактын 12.1 дүгээр зүйлийн дагуу энэхүү Пактад нэгдсэн улс “бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх хүн бүрийн эрхийг” хүлээн зөвшөөрч, мөн 12.2 дугаар зүйлд “энэ эрхийг хүн бүрэн гүйцэд утгаар нь эдлэхэд ...” гишүүн орнуудын зүгээс хийх алхам, арга замуудыг заасан байна.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг зөвхөн эрүүл мэндийн зохистой үйлчилгээгээр цаг хугацаанд нь үйлчлүүлэх эрхээр хязгаарлалгүй, хүний эрүүл байх нөхцлийг бүрдүүлэгч

эрүүл аюулгүй ундны ус, шаардлагад нийцсэн ариун цэврийн нөхцөл, хоргүй хоол хүнсний хангамж, орон байр, ажлын нөхцөл, байгаль орчны эрүүл байдал, мөн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл авах зэрэг асуудалд хүн амыг өргөн татан оролцуулах нь нэн чухал юм.

Төрийн хүлээх үүрэг

Төр нь Монгол Улсын хууль тогтоомж, Олон улсын гэрээ, Конвенцид заасны дагуу хүний эрхийг зөрчихгүй, хүний эрхээ хэрэгжүүлж болох нөхцлүүдийг бий болгох үүрэгтэй байдаг. Үүний дотор хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн талаар дараах үүргийг төр хүлээдэг байна. Үүнд:

- **Хүндлэх** – эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, алагчлахгүй байх зарчмын дагуу хүртээхэд саад учруулахгүй байх үүрэгтэй. Түүнчлэн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны бохирдлыг бий болгож болохуйц үйл ажиллагаа гэх мэт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үйлдлийг зогсоох.
- **Хамгаалах** – эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд хүн бүр тэгш эрхтэйгээр хүртэх боломжийг хангах эрх зүйн орчинг бүрдүүлж, бусад арга хэмжээг авах.
- **Баталгаажуулах** – үндэсний эрүүл мэндийн бодлогыг хүлээн зөвшөөрөх, төсвөөс хангалттай хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулах, шаардлагатай үйлчилгээгээр хангах буюу хувь хүн шаардлага хангасан, хангалттай үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд эрүүл мэндийн асрамж, сувилгааны үйлчилгээ, ундны цэвэр ус зэрэг орно.

Хүн амын эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах үүднээс зарим эрх нь хязгаарлагдаж болох ба олон улсын стандартаар дараах шаардлагуудыг хангасан байх ёстой. (Жишээ нь: халдварт өвчнөөс болон хорио цээртэй холбогдож дамжин өнгөрөх эрхийг хязгаарлаж болох). Үүнд:

- Хязгаарлалтууд нь үндэсний хууль тогтоомжид заагдсан байх ёстой.
- Хууль ёсны дагуу хязгаарлалтыг заавал хэрэгжүүлэх ёстой.
- Тодорхой хугацаатай байх ба шаардлагатай тохиолдолд дахиж хянаж үзэхэд бэлэн байх ёстой.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн үндсэн зарчим

Олон улсын хэмжээнд хүний эрхийн тодорхой зарчмууд үйлчилдэг. Хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн зарчмууд нь хүний эрхийн зарчмуудтай нийцэж байхаас гадна өөр, өөрийн онцлогтой. Үүнд:

- **Хүрэлцээ:** Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний байр, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, эм, тариа, үйлчилгээ, эмч, эмнэлгийн ажилтнууд, хөтөлбөр зэрэг нь хүн бүрт хүрэлцэхүйц хэмжээнд байх шаардлагатай.
- **Хүртээмжтэй байх:** Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, тусламж, үйлчилгээ зэрэг нь хуулийн хүрээнд, хэнийг ч ялгаварлалгүйгээр хүн бүрт хүртээмжтэй байх ёстой. Хүртээмжтэй байдал гэдгийг дараах дөрвөн хүрээнд ойлгоно. Үүнд:
 - 1) **Ялгаварлан гадуурхахгүй байх:** эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эмнэлгийн үйлчилгээ, сувилгаа нь бүх нийтэд нэгэн адил ялгаварлалгүйгээр хүртээлтэй байх.
 - 2) **Бодит хүртээмж:** эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, үйлчилгээ нь хүн амын бүхий л хэсэгт, ялангуяа эмзэг ба үндэстний цөөнхүүд, эмэгтэйчүүд, өсвөр насныхан, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй ба ХДХВ/ДОХ-оор өвдсөн зэрэг бүхий л хүмүүст хангалттай, бодит хүртээмжтэй байх.
 - 3) **Эдийн засгийн боломж:** эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, эмчилгээ, үйлчилгээ нь бүх хүмүүст төлж чадахуйц боломжийн үнэтэй байх.
 - 4) **Мэдээлэл авах боломж:** эрүүл мэндийн асуудалтай холбоотой мэдээллийг хайх, олж авах, түгээх, илэрхийлэх боломж юм. Гэхдээ хувь хүний эрүүл мэндийн тухай мэдээллийг тараах учиргүй¹³.
- **Сэтгэлд нийцсэн байх:** Эмнэлгийн тоног төхөөрөмж, эм тариа, эмчилгээ, үйлчилгээ нь анагаах ухааны ёс зүй, хувь хүний онцлогт тохирсон байх шаардлагатай.
- **Чанар:** Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, эмчилгээ үйлчилгээ нь хувь хүний онцлогт тохирсон байхаас гадна шинжлэх ухаан, анагаах ухааны шаардлагад нийцсэн сайн чанартай байх ёстой. Мөн дадлага туршлагатай эмнэлгийн ажилтнууд, шинжлэх ухаанаар батлагдсан хугацаа нь дуусаагүй эм тариа, багаж төхөөрөмжөөр хангагдсан байх шаардлагатай.

Монгол улсад эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилт

2007 оны эцсийн байдлаар Монгол Улсын хүн ам 2 сая 635.2 мянгад хүрсэн бөгөөд 2006 онтой харьцуулахад 31.8 мянган хүн буюу 1.2 хувиар өссөн байна¹⁴. Нас баралт багасаж байгаа нь иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх хэрэгжиж байгааг илтгэж байгаа юм.

¹³ МУ-ын Хувь хүний нууцын тухай хууль, 4.2.2 дугаар хэсэг, 1995 он

¹⁴ “Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2007” /ЭМХҮТ/, 2008 он

Монгол Улс нь засаг захиргааны нэгжийн хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагдана¹⁵. Одоогийн байдлаар Монгол Улс 21 аймаг, 340 сум, 1645 багтай. Нийслэл нь 9 дүүрэг, 132 хороодод хуваагдаж байна.

Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг 15, бүсийн эмчилгээ оношилгоо эмчилгээний төв 3, аймгийн нэгдсэн эмнэлэг 18, дүүргийн нэгдсэн эмнэлэг 9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 4, сум дундын эмнэлэг 35, сумын эмнэлэг 288, өрхийн 229 эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа¹⁶ бөгөөд ойролцоогоор нийт 6365 их эмч ажиллаж байна. Эдгээр эмнэлгүүдийг 3 шатлалд ангилсан байна. Үүнд:

Анхан шатны эмнэлэг- хүн амд зайлшгүй болон эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- ❖ Өрхийн эмнэлэг
- ❖ Сумын эмнэлэг
- ❖ Сум дундын эмнэлэг

2 дахь шатны эмнэлэг- үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- ❖ Аймгийн нэгдсэн эмнэлэг
- ❖ Дүүргийн нэгдсэн эмнэлэг
- ❖ Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /зөвхөн Ховд, Дорнод, Өвөрхангай аймгуудад үйл ажиллагаа явуулдаг./

3 дахь шатны эмнэлэг - улсын хэмжээнд төрөлжсөн, мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- ❖ Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг /зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг/

Энэ эрхийн хэрэгжилт нь өнгөрсөн онд Эрүүл мэндийн яамны шугамаар хөдөөгийн эмнэлгүүдийн эмчилгээ, оношлогооны багаж, тоног төхөөрөмж, аппарат хэрэгслийн хангалтыг сайжруулахын тулд 10 нэр төрлийн дижитал, уян дурангийн иж бүрдлээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төв 2, 3 аймаг, хавдар судлалын үндэсний төвийг; шинээр ашиглалтанд орсон 5 аймгийн 5 суманд эмнэлгийн техник хэрэгслээр; дижитал рентген аппарат, зураг угаагчийн хамтаар улсын клиникийн төв эмнэлэг болон төрөлжсөн 5 эмнэлгийг; телевизийн системтэй суурин рентген аппаратаар 5 аймаг, 3 дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдлийг; эх барих, эмэгтэйчүүдийн болон лабораторийн анализаторуудаар 21, аймгийн нэгдсэн эмнэлэг, 8 дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, 3

¹⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн хоринтавдугаар зүйлийн 25.1, 1992 он

¹⁶ “Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2007” /ЭМХҮТ/, 2008 он

төрөх газруудыг, “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 300 сумын эмнэлгийг 10 нэр төрлийн лабораторийн техник хэрэгслээр тус тус хангасан байна¹⁷.

Засгийн газраас “Эрүүл мэндийн технологийг сайжруулах”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Орчны эрүүл мэнд”, “Эрүүл монгол хүн”, “Халдварт болон Халдварт бус өвчинтэй тэмцэх” зэрэг гол болон зонхилох бусад өвчнийг буруулах багасгах, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн 10 гаруй салбарын болоод үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна¹⁸.

“Эрүүл мэндийн салбар дахь сайн засаглалын ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг анагаах ухааны салбарт мөрдөж буй шинэ хандлага, үйлчилгээний өнөөгийн хэрэгцээ, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ сонирхлыг харгалзан шинэчилж мөрдүүлж, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах эмнэлгийн ажилтны ёс зүйг дээдлэгч байгууллага, хамт олон шалгаруулах болзолт уралдаан зарлах зэрэг зохион байгууллалтын арга хэмжээ авчээ.

Мянганы хөгжлийн зорилт, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний 3 дахь хөтөлбөрийн дагуу эхийн эндэгдлийг бууруулах цогцолбор арга хэмжээ авч зарим талаар үр дүнд хүрч буйн зэрэгцээ өрхийн эмнэлгийг дэмжихийн тулд өрхийн эмнэлгийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн хэмжээгээр өрхийн эмнэлгүүд бүртгэгдсэн хүн амд үйлчилж байгаа бөгөөд харъяалалгүй, бүртгэлгүй иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг болсон байна.

Эм, эмнэлгийн тусламж үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй үзүүлэх журмыг эрүүл мэндийн тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийг үндэслэн 2006 оны эрүүл мэндийн сайдын 393 дугаар тоот тушаалын хавсралтаар баталсан байна¹⁹.

Эрүүл мэндийн үндэсний төвөөс жил бүр гаргаж байгаа “Эрүүл Мэндийн Үзүүлэлтүүд 2007” судалгаанаас харахад манай улсад халдварт, халдварт бус өвчин, зүрх судасны өвчин дээгүүр үзүүлэлттэй байна. Харин эхийн эндэгдэл, зарим халдварт өвчин буурах хандлага байгаа.

Хүний эрхийн үндэсний комиссын 2008 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-д иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаанд төр, засгаас анхаарал тавьж байгааг тусгаж, цаашид анхаарал хандуулах шаардлагатай асуудлуудын талаар дурьдсан байна.

¹⁷ “Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2007” /ЭМХҮТ/, 2008 он

¹⁸ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, /ХЭҮК/, 2008 он, 18-19 хуудас

¹⁹ “Төр хариуцах тусламж, үйлчилгээний тухай” Эрүүл мэндийн сайдын тушаал, 393 дугаар тоот, 2006 он

Дүгнэлт

Төрөөс хүн амын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаануудыг эрчимтэй явуулж, ахиц дэвшилт гарч байгаа боловч хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн талаар анхаарч үзвэл зохих дараах зүйлүүд анхаарал татаж байна. Үүнд:

- Зарим халдварт өвчний тархалт жилээс жилд ихэсч байна. /БЗХӨ/ ХДХВ, тэмбүү, гепатит/
- Зарим халдварт бус өвчин ихсэх хандлагатай байна. /Зүрх судасны, амьсгалын замын, хаврын өвчлөл/
- Эхийн эндэгдэл
- Монгол улсад зарим нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ хийгдэхгүй байна. Иргэд БНХАУ, БНСУ, ОХУ, Япон зэрэг орнууд руу эмчилгээ хийлгэхээр зорьж байгаа өөрийн оронд иргэд эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ эдэлж чадахгүй байгаагийн нэгэн тод жишээ болж байна.



Ч.АЛТАНГЭРЭЛ

Хүний эрхийн Үндэсний Комиссын
референт

БОЛОВСРОЛ ДАХЬ ЭРХЭД СУУРИЛСАН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭ

Боловсролын салбарт эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэхийн тулд боловсрол хүртээмжтэй байх, чанартай боловсрол эзэмших, боловсролын харилцаанд хүний эрхийг хүндэтгэхэд чиглэсэн үзэл баримтлалын хүрээ байх шаардлагатай. Эдгээр хандлагууд нь өөр хоорондоо уялдаатай, харилцан нөхцөлдсөн бөгөөд бүгд нэгэн зэрэг хэрэгжиж байж эрхэд суурилсан боловсрол хэмээн үзнэ. Сурч боловсрох эрх нь бүх нийтэд хүртээмжтэй байх бололцоог хангахыг эрхэмлэж, нийгмээс тусгаарлагдсан хүүхдүүдэд хүрэх арга хэмжээг агуулсан байвал зохино. Хүүхдүүд зөвхөн сургуульд явах нь хангалттай бус бөгөөд мөн боловсрол нь тухайн хүүхэд эдийн засаг, нийгмийн зорилгоо биелүүлж, идэвхитэй, хариуцлагатай иргэн болоход шаардагдах мэдлэг, чадвар, хандлагыг эзэмших баталгаа болж чадахгүй юм. Зүүн болон өмнөд Африкийн Боловсролын чанарын үнэлгээний консорциумын судалгаа (1995-1998)-нд уншихуйн үндэсний шинжээчид болон зургаадугаар ангийн багш нарын боловсруулсан стандарттай бага сургуулийн сурагчдын унших чадварыг харьцуулан үнэлжээ. Судалгаанд оролцсон долоон орны дөрвийнх нь сурагчдын тэн хагасаас бага хувь нь уншихуйн стандартын хамгийн наад захын чадамжийг эзэмшсэн нь тогтоогджээ²⁰.

Мөн франц хэлтэй Африкийн 6 оронд 1996-2001 онд зохион байгуулсан *Programme d'Analyse des Systemes Educatifs de la CONFEMEN* (PASEC) судалгаагаар тэдгээр оронд сургалтын амжилт хангалтгүй болох нь тогтоогджээ. Судалгаанд хамрагдсан 6 орны 5 дугаар ангийн хүүхдүүдийн 43 % нь франц хэл, математикийн хичээлээр үнэлгээний сул түвшинд тооцогдож, Сенегалын сурагчдын 40 гаруй хувь нь 2 бутархайтай цөөн онооны

²⁰ United Nations Educational, Scientific and Cultural Organization, EFA Global Monitoring Report 2005: The quality imperative, UNESCO Publishing, Paris, 2004, p. 121. CONFEMEN stands for Conférence des ministres de l'Éducation des pays ayant le français en partage (Conference of Education Ministers of French-speaking Countries).

төлөө өрсөлдөж байна²¹. Чанартай боловсрол олгох нь хөгжингүй орнуудын хувьд ч томоохон сорилт гэж үздэг. Саяхан хийгдсэн судалгааны дүнгээр чинээлэг орнуудын олонх сурагчид өнөөгийн өрсөлдөөнт нийгмийн шаардаж буй суурь чадваруудыг эзэмшээгүй болох нь тогтоогджээ²².

Дакарын Үйл ажиллагааны хүрээ (2002) болон Хүүхдийн эрхийн хорооны Боловсролын зорилгын тухай зөвлөмж²³ зэрэгт чанартай боловсрол олгохын тулд тохиромжтой хөтөлбөр, багш нарын үүрэг, сургалтын орчны чанар ба ёс зүйн асуудалд онцгойлон анхаарал хандуулах ёстой ажээ. Эрхэд суурилсан хандлагаар сургуулийн орчинд хүүхдийн бие даасан байдал, хувь чанарыг хүндэтгэн, эрхийг нь хүлээн зөвшөөрч хангах ёстой. Үүний үр дүнд боловсролын гэгээрүүлэх, оролцоог хангах, нээлттэй ил тод байх үйл явцыг дэмжих болно. Мөн алагчлалаас ангид байх эрх, зохистой нөхцөлд амьдрах болон утга учиртай, зөв оролцоход чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хүүхэд эрүүл, сайн сайхан амьдрахгүйгээр чанартай боловсрол эзэмшиж чадахгүй. Мөн хүүхдүүд бие махбодийн шийтгэл хүлээж, хүчирхийлэлд өртсөнөөр бүрэн дүүрэн хөгжиж чадахгүй билээ.

Энэхүү үзэл баримтлалын хүрээ нь боловсрол дахь хүний эрхийн түгээмэл байх, хуваагдашгүй байх зарчмуудыг цогц байдлаар тусгасан. Дээр дурдсан 3 үндсэн хандлагын голлох бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар дараах хэсэгт авч үзнэ.

1.Боловсрол хүртээмжтэй байх эрх	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд төрсөн үеэс эхлэн насан турш сурч боловсрох • Боловсрол нь боломжтой, нийцтэй байх • Тэгш бололцоо олгох
2.Чанартай боловсрол эзэмших эрх	<ul style="list-style-type: none"> • Өргөн хүрээтэй, амьдралд нийцтэй, тэгш хамруулах хөтөлбөр • Эрхэд суурилсан сургалт ба үнэлгээ • Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин
3.Сургалтын орчинд хүндэтгэл хүлээх эрх	<ul style="list-style-type: none"> • Ялгаатай байдлыг хүндэтгэх • Оролцох эрхийг хүндэтгэх • Нэгдэл нягтралыг хүндэтгэх

²¹ Мөн тэнд, 122 хуудас

²² United Nations Children's Fund, 'A League Table of Disadvantage in Rich Nations', Innocenti Report Card No. 4, UNICEF Innocenti Research Centre, Florence, November 2002, p. 7.

²³ Committee on the Rights of the Child, 'General Comment No. 1: The aims of education, article 29 (1) (2001)',

CRC/GC/2001/1, 2001, para. 9.

БОЛОВСРОЛ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙХ ЭРХ

Боловсрол хүртээмжтэй байх эрхийг хангахтай холбогдох үүрэг

- Бага боловсролыг үнэ төлбөргүй заавал эзэмшүүлэх
- Хүн бүр дунд боловсрол эзэмших бололцоог бүрдүүлэх, боловсрол үнэ төлбөргүй байх болон шаардлагатай тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах
- Хүн бүр өөрийн чадавхид тулгуурлан дээд боловсрол эзэмших боломжтой байх
- Боловсролын ба мэргэжлийн холбогдолтой мэдээлэл, заавраар хангах
- Сургуульд хамрагдалтыг ихэсгэж, завсардалтыг бууруулах арга хэмжээ авах
- Тэгш бололцооны үндсэн дээр боловсролын үйлчилгээ үзүүлэх
- Ямар нэгэн үндэслэлээр алагчлалд өртүүлэхгүй, сурч боловсрох эрхийг нь хангах
- Боловсролын бүхий л тогтолцоонд тэгш хамруулан сургах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгэмшлийг аль болох дээд зэргээр хангахуйц, зохистой боловсрол эзэмшихийг дэмжих арга хэмжээ авах, зохистой орон байраар хангах
- Бие, сэтгэл санаа, оюун ухаан, ёс суртахууны болон нийгмийн хөгжлийн зохистой түвшинд амьдрах эрхийг хангах
- Дүрвэгч болон улс төрийн орогнол хүсэж байгаа хүүхдийн эрхийг хангахын тулд шаардлагатай хамгаалалт, дэмжлэг үзүүлэх
- Эдийн засгийн мөлжлөг болон сурч боловсроход саад болохуйц хөдөлмөрөөс хамгаалах

Эх сурвалж: Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 26 зүйл; Хүүхдийн эрхийн тухай конвенц, 2, 22, 23, 27, 28, 32 зүйлүүд; Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 13 зүйл; Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, 10 зүйл; Боловсрол дахь алагчлалын эсрэг ЮНЕСКО-ын Конвенц, 4, 5 зүйл; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (2007 оны 3 сарын 30-наас гарын үсэг зурж эхэлсэн) 24 зүйл;

Боловсрол хүртээмжтэй байх эрх нь хүүхэд байхаасаа эхлэн насан турш сурч боловсрох, Бүх нийтийн боловсролын зорилтуудыг хангах, сургууль болон сурах нөхцөл хангалттай, хүртээмжтэй байх, тэгш бололцоо олгох гэсэн 3 үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг.

Хүүхэд байхаасаа эхлэн насан турш сурч боловсрох

Суралцах нь насан туршийн үйл явц байдаг. Боловсрол дахь эрхэд суурилсан хандлага нь хүүхэд насандаа болон түүнээс цааш өөрийн дээд чадавхийн хирээр сурч боловсрох бололцоог бүрдүүлэхийг эрмэлздэг. Энэ нь хүүхдийн амьдралын үе шат бүрд зохистой өөрчлөлт хийж, суралцахуйг дэмжих амьдралын мөчлөг бүхий үйл явц

байна. Хэдийгээр Хүүхдийн эрхийн тухай конвенцид бага насны хүүхдэд боловсрол олгох тухай тодорхой заалт байхгүй ч Хүүхдийн эрхийн хороо сурч боловсрох эрх нь хүүхдийг төрснөөр эхлэх бөгөөд хүүхдийн эрхийг аль болох дээд түвшинд хангах үндэс болно гэж тайлбарласан. Энэ нь засгийн газруудыг бага насны хүүхдийг эрүүл байх, сайхан амьдрахад туслахуйц боловсрол олгоход уриалж, бага насны хүүхдийн боловсролыг эцэг эхийн оролцоотойгоор тогтолцоот байдлаар олгоход чухал болохыг тэмдэглэсэн байдаг.

Бага насанд нь чанартай боловсрол олгох нь сургуульд бэлтгэж, улмаар эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих, Мянганы хөгжлийн зорилтууд ба Бүх нийтийн боловсролын үзэл санааг хэрэгжүүлэх баталгаа болж өгнө²⁴. Непал улсад хийсэн судалгаагаар сургуулийн өмнөх албан бус сургалтанд хамрагдсан хүүхдүүдийн 95% нь бага боловсролд хамрагдаад, уг сургалтанд хамрагдаагүй бусадтайгаа харьцуулахад ихээхэн давуу талтай болсон нь харагджээ. Эхний бүлгийн хүүхдүүдийн 80% нь 1 дүгээр анги амжилттай төгссөн бол сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 60%-тай байна²⁵.

Хүний эрхийн баримт бичгүүдэд хүүхэд бүрт суурь боловсролыг үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэх үүрэг ноогдуулдаг. Энэ үүрэг нь боловсролыг хүүхэд бүрт тохиромжтой, хүртээмжтэй, мөн боломжтой бол үнэ төлбөргүй байхаар зохион байгуулахыг уриалж байна. Олонх орны хувьд боловсролыг үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэхийг хүлээн зөвшөөрч байгаа боловч уг амлалт нь одоогийн байгаа нөөцөөс давсан зүйл юм²⁶. Мөн дээрх гэрээ конвенциудын эхийг бэлтгэх үед суурь боловсрол чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрч байсан юм.

Хөгжлийн үйл явц ч 18 нас хүрээд зогсдог зүйл биш. Боловсролыг өсвөр үеийнхэн болоод насанд хүрэгчдэд амьдрах ухааны хөтөлбөр боловсруулах тухай уриалсан Бүх нийтийн боловсролын 3 дахь зорилттой нийцүүлэн өөрчлөх ёстой. Төр нь бие даасан, хариуцлагатай, иргэний чадвартай болгон бэлтгэхүйц насан туршийн суралцахуйн бааз суурьт дэмжлэг үзүүлэх ёстой.

²⁴ United Nations Educational, Scientific and Cultural Organization, EFA Global Monitoring Report 2007: Strong foundations – Early childhood care and education, UNESCO, Paris, 2006, p. 12.

²⁵ Save the Children, 'What's the Difference? The impact of early childhood development programs', Save the Children, Kathmandu, 2003, pp. 21, 32.

²⁶ Hodgkin, Rachel, and Peter Newell, Implementation Handbook on the Convention on the Rights of the Child, United Nations Children's Fund, New York, 2002, p. 379.

Боловсролын хүртээмжтэй ба боломжтой байдал

Төр бүх хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахуйц эрх зүйн болон бодлогын хүрээ, нөөцийн хамт бүрдүүлэх үүрэгтэй. Хүүхэд бүр сургуулийн тодорхой орон зай буюу сурах нөхцөл, мэргэжсэн багш, зохих шаардлага хангасан хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх ёстой²⁷. Тухайлбал бага боловсрол олгох бололцоо нь уг боловсрол эзэмших хүүхдийн тоотой нийцэж байх ёстой.

Бүхий л сургалтын орчин нь бүх хүүхдэд ялангуяа тусгаарлагдмал, эмзэг бүлгийн хүүхдүүдэд нөхцлийн хувьд ч, эдийн засгийн хувьд ч адил тэгш хүртээмжтэй байна. Сургууль нь аль нэгэн хүүхдийн хувьд хүртээмжтэй хэдий ч харин нөгөө хүүхдийн сурч боловсрох бололцоог хангахгүй байж болохыг анхаарах нь чухал юм. Сургуулиуд нь сурагчдын эрүүл мэндэд аюулгүй, зайны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр шинэ технологийн дэвшилд үндэслэн сурч боловсрох боломжийг хангаж байвал зохино. Мөн үүний хамт боловсрол нь бүх хүн хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой билээ²⁸.

Тэгш бололцоо олгох нь

Сургуульд суралцах бололцоо хүүхэд бүрд тэгш байна. Сургуульд суралцах бололцоо нээлттэй байх нь чухал боловч уг эрхийг хэрэгжүүлэх хангалттай нөхцөл биш юм²⁹. Харин нийгэм болон сургуулиудад тохиолдож буй саад бэрхшээлүүдийг арилгаснаар уг тэгш бололцоо олгогдоно. Хэрвээ сургуулиудад хүйсийн ялгаа, хөгжлийн бэрхшээл, ДОХ, өрхийн ядуурал, үндэстэн, цөөнхийн статусаар ялгаварлан харилцах, өнчин хүүхдүүд, хүүхдийн хөдөлмөр зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын хүчин зүйлсүүд байх аваас хүүхдүүд сургуулиас завсардахад хүрдэг. Төр, гэр бүл болон нийгмийн харилцаанд хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад саад болж буй бэрхшээлийг арилгаж, эрх зүй, бодлого болон дэмжлэгийн тогтолцоог хамт бүрдүүлэх үүрэгтэй.

Сургуулиуд шууд болон шууд бус хэлбэрээр, тухайлбал эрэгтэй давамгайлсан соёл тогтсон, хүчирхийллийн хэлбэрүүд, бэлгийн халдлага түгсэн, кастын ялгаварлал зэрэг нийгмийн хэм хэмжээ зонхилсон бол зарим хүүхдийн хувьд боловсрол хүртээмжтэй байж чадахгүй. Охидод сөрөг хандах багшийн хандлага, хөтөлбөр дэх ялгаварлал, эмэгтэй багш нар ховор, нөлөөлөл бага байх, ариун цэвэр, эрүүл ахуйн хангалтгүй байдал зэрэг нь сургуульд хамрагдалтыг бууруулж, амжилтгүй сурах, олноороо сургууль завсардахад хүргэдэг³⁰. Тэр

³⁰ United Nations Children's Fund, The State of the World's Children 2004: Girls, education and development, UNICEF, New York, 2003, pp. 71, 84, 87.

²⁷ Committee on Economic, Social and Cultural Rights, 'General Comment No. 13: The right to education (article 13)', E/C.12/1999/10, December 1999, para. 50.

²⁸ Мөн тэнд.

²⁹ Committee on Economic, Social and Cultural Rights, 'General Comment No. 13: The right to education (article 13)', E/C.12/1999/10, December 1999, para. 50.

бүү хэл зарим сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй болон ДОХ-той хүүхдийг сургахаас татгалздаг. Сургуулийн тогтолцоо нь ажиллаж байгаа хүүхдүүдийг үл хайхардаг. Төрөөс боловсрол нь тэгш хамруулсан, үл алагчилсан, хүүхэд бүр суралцах адил бололцоотой байлгах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ЭРХ

Чанартай боловсрол эзэмших эрхийг хангахтай холбогдох үүрэг

- Хүүхдийн хувийн чанар, авъяас билэг, оюуны болон биеийн чадварыг дээд хэмжээнд хөгжүүлэх
- Хүний эрх, эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болгоход чиглүүлэх, хүүхдийг энх тайван, хүлцэн тэвчил, найрамдал нөхөрлөл, тэгш байдлын үзэл санаагаар хүмүүжүүлэх
- Хүүхэд, тэдний эцэг эх, бусдын соёл, хэл, үнэт зүйлсийн ялгааг хүндэтгэх
- Хүрээлэн буй байгаль орчныг хайрлан хамгаалах
- Төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл олж авах эрхийг хангах
- Хүүхдийн ашиг сонирхлыг тэргүүн зэрэгт тавих
- Хүүхэд эрхээ эдлэх чадавхи, бололцоог хүндэтгэх
- Хүүхэд амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, тоглох, урлаг соёлын үйл ажиллагаанд оролцох эрхийг хүндэтгэх

Дакарын үйл ажиллагааны хөтөлбөр нь чанартай бага боловсрол олгох болон боловсролын чанарыг бүх агуулгаар нь сайжруулахыг улс орнуудад үүрэг болгосон юм³¹. Хэдийгээр “чанар” хэмээх ойлголтыг нэг мөр тодорхойлоогүй боловч үүнд дараах үндсэн хоёр зарчмыг тусгасан байдаг. Нэгдүгээрт боловсролын үндсэн зорилго бол танин мэдэхүйн хөгжил бөгөөд уг зорилгод хүрж байгаа амжилтаар нь боловсролын эцсийн үр дүнг хэмждэг. Хоёрдугаарт, боловсрол нь хойч үеийнхэнд дэлхий нийтийн болон үндэсний соёлын үнэт зүйлсийг дамжуулах, тэгш байдлыг бий болгох, иргэншил, энх тайван, аюулгүй байдлын үзэл санааг дэмжих зэрэг оюуны, бүтээлч үйл ажиллагаа байна. Эдгээр зарчмууд нь хүүхдийг хувь хүнийх нь хувьд хүндэтгэх, мөн хэрэгцээ сонирхол, эрх ашиг, чадварын хувьд бие даасан болохыг хүлээн зөвшөөрсөн Хүүхдийн эрхийн тухай конвенцийн үзэл санаанд нэгтгэн авч үзэх ёстой³². Энэ нь хүүхдийн хөгжлийг дээд зэргээр хангах боловсролд холбогдох үүрэг хариуцлагын хүрээг тодорхойлсон юм.

Эх сурвалж: Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 26 зүйл; Хүүхдийн эрхийн тухай конвенц, 3, 5, 6, 12, 17, 29, 31 зүйлүүд; Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 13 зүйл; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (2007 оны 3 сарын 30-наас гарын үсэг зурж эхэлсэн) 24 зүйл;

³¹ United Nations Educational, Scientific and Cultural Organization, EFA Global Monitoring Report 2005: The quality imperative, UNESCO Publishing, Paris, 2004, p. 28.

³² Thomas Hammarberg, former vice-chair of the Committee on the Rights of the Child, quoted in Centre for Studies on Inclusive Education, 'Inclusive Education: A framework for change – National and international perspectives', CSIE, Bristol, 1997, p. 6.

39 дүгээр зүйлд “боловсрол нь хүүхэд төвтэй, хүүхдэд ээлтэй, гэгээрүүлэгч байх бөгөөд конвенциор тунхагласан зарчмуудыг боловсролын үйл ажиллагаанд тусгах шаардлагатайг онцолсон байдаг³³. Хүүхэд бүр түүний амьдрах ухаан, суралцах болон бусад чадвар, өөртөө итгэлтэй бие даасан байлдлыг хөгжүүлэхүйц боловсрол эзэмших эрхтэй. Чанартай боловсрол нь хөтөлбөрийн агуулга, заах арга, сургалтын орчин зэрэгт ч мөн хамаатай. Хүүхдийн бүх хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй, тохиромжтой, хүндэтгэл бүхий сургалтын орчин байна гэсэн үг.

Өргөн хүрээт, зохистой, тэгш хамруулах хөтөлбөр

Хүний эрхийн бүхий л үндсэн баримт бичгүүдэд эрхэд суурилсан боловсролын агуулга, хэрэгцээ, үндэслэлийг тодорхойлсон хөтөлбөр боловсруулах нь чухал хэмээн нийтлэг ойлголцол бий болсон байна. Уг хөтөлбөр нь хүүхэд бүрт тохиолдож болох сорилтуудыг даван туулах, эрүүл амьдралын хэв маягийг бүрдүүлэх, нийгмийн сайн харилцаа холбоо тогтоох, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, тэнцвэртэй шийдвэр гаргахуйн академик үндсэн агуулга, танин мэдэхүйн суурь чадварууд, амьдрах ухааныг хөгжүүлэхүйц байх ёстой. Мөн хүний эрх, эрх чөлөө, ялгаатай соёл хийгээд үнэт зүйлс, байгаль орчныг хүндэтгэхэд чиглэх шаардлагатай. Хүүхдийн эрхийн хорооноос бага насны хүүхдэд зориулсан болон сургуулийн хөтөлбөр нь “хүүхдийн нийгэм, эдийн засаг, соёл, хүрээлэн буй орчны нөхцөл байдал, өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хүүхдийн чадварыг дэмжихэд чиглэсэн байх тухай заасан байдаг³⁴.

Хөтөлбөр нь мөн ялгаатай хийгээд хүнд нөхцөлд байгаа хүүхдийн хэрэгцээ шаардлага нийцсэн байх ёстой. Аливаа сургалтын материалууд нь жендерийн ялгаа бүхий хэвшмэл ойлголтууд, уугуул болон аль нэгэн үндэстний бүлгийг сөргөөр буюу хортой байдлаар дүрслэхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд мөн Брайль үсэг, дохионы хэл зэрэг тэдний чадварт нийцсэн, зохистой байдлаар суралцах боломжийг хангаж өгвөл зохино.

Эрхэд суурилсан суралцахуй ба үнэлгээ

Тухайн хүүхдэд сурч боловсрох бололцоо байгаа эсэх нь тэд юу сурч байна вэ гэдэгтэй нэгэн адил чухал билээ. Мэдээллийг идэвхигүй байдлаар хүлээн авдаг, дуугүй байдаг зэрэг шинж бүхий уламжлалт сургалтын загвар нь эрхэд суурилан суралцах хандлагад нийцэхгүй юм.

³³ Committee on the Rights of the Child, ‘General Comment No. 1: The aims of education, article 29 (1) (2001)’, CRC/GC/2001/1, 2001, para. 2.

³⁴ Мөн тэнд, 9 дүгээр зүйл

Хүүхэд, өсвөр үеийнхэн боловсролын идэвхигүй хүлээн авагч бус харин өөрийн сурах үйлийг идэвхитэй хэрэгжүүлэгч хэмээн үзэх ёстой³⁵. Хүүхэд шилжилтийн насан дээрээ бүх мэдлэг, чадварыг эзэмшээгүй байдгийг хүлээн зөвшөөрөхийн хамт тэдний өөрчлөгдөж, хөгжиж буй чадавхийг хүндэтгэнэ³⁶. Сургалт нь оролцооны орчин бүрдүүлж, хүмүүсийг идэвхижүүлсэн интерактив арга зүйг өргөнөөр ашиглах шаардлагатай. Мэдлэгийг шууд дамжуулах бус оролцоонд үндэслэсэн сургалт зохион байгуулж, суралцах боломжоо нэмэгдүүлэх орчныг хангахад багш оролцоно. Сургалтын орчин нь хүүхдийн чадавхийг дээд зэргээр хөгжүүлэх, хүүхдэд ээлтэй байна.

Сурлагын амжилтыг хэрхэн үнэлэх нь нэн чухал байдаг. Тест авах нь сургуулиуд суралцагчдын хэрэгцээ сонирхлыг мэдэж, тэдэнд дэмжлэг үзүүлэх талаар санаачлага гарган ажиллах боломжийг бүрдүүлнэ. Засгийн газар боловсролын талаарх зорилтуудын хэрэгжилт, үр дүнд анализ хийснээр бодлого, нөөцийг түүнд нийцүүлэн зөв хуваарилах боломжийг олно. Уг үр дүнгийн талаар мэдээлэл түгээх нь боловсролын чанарын талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж, боловсрол дахь нээлттэй, ил тод байдлыг дэмжинэ. Үүний хамт хүүхдийн эрхийг аль болох дээд зэргээр хангах амлалт нь хүүхдийн сурах хэрэгцээнд үндэслэн алагчлахгүй байх, үнэлгээний үр дүнтэй, мэдрэмжтэй арга зүйг боловсруулахыг шаарддаг.

Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин

Хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, хөгжлийг дээд зэргээр хангах үүрэг хариуцлага нь таатай, жендерийн мэдрэмжтэй, эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчин бүрдүүлэх явдал юм. Хэдийгээр ядуурал, онцгой байдал, зөрчилдөөн зэрэг нөхцлүүд саад болж болох ч хүүхдүүд тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдалд хор уршиг учруулахуйц орчинд суралцана гэж үзэж огт болохгүй. Мөн сургуулиуд ч хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхан байдал, хэрэгцээ сонирхлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай байдаг. Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулж болох хүчин зүйлс тухайлбал сургуулийн байршил, сургуульд ирэх болон явах тээврийн хэрэгсэл, анги болон тоглоомын талбай дахь осол гэмтэл гарч болох саад бэрхшээлүүдийг арилгах, охидод зориулсан шаардлагатай тоноглолыг хангах ёстой. Мөн хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах бодлого, тоног төхөөрөмж, үйлчилгээг хүргэхэд орон нутгийн хүмүүс, орчны идэвхитэй оролцоог хангах нь зүйтэй. Тоглох наадах, чөлөөт цагаа өнгөрүүлэх бололцоо бүхий аюулгүй орчин бүрдүүлэх шаардлагатай билээ.

³⁵ Мөн тэнд, 8 дугаар зүйл

³⁶ Мөн тэнд, 12 дугаар зүйл

СУРАХУЙН ОРЧИНД ХҮНДЭТГЭЛ ХҮЛЭЭХ ЭРХ

Сурахуйн орчинд хүүхдийн эрхийг хүндэтгэх үүрэг

- Ямар нэгэн үндэслэлээр алагчлахгүй, хүүхэд бүрийг адил тэгш хүндэтгэх
- Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, энх тайван, хүлцэн тэвчил, тэгш байдал, найрамдал нөхөрлөл болон нийгэм дэх амьдрал, ялгаатай байдлын тухай заах
- Хүүхдийн ашиг сонирхлыг тэргүүн зэрэгт тавих
- Хүүхдийн өсөн нэмэгдэж буй чадварыг дэмжих
- Хүүхэд өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүлээн зөвшөөрч, тэдний нас, төлөвшлийг харгалзан үзэл бодолд нь зохих ач холбогдол өгөх
- Үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх зэрэг эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх
- Хүүхдийн хувийн нууцыг хүндэтгэх
- Хүүхдийн эрхэм чанар болон Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасан бүх эрхэд нийцүүлэн сургуульд сахилга бат, дэг журмыг тогтоох арга хэмжээ авах
- Хүүхдийн бие махбодид халдах, дарамтлах, гүтгэн доромжлох, үл хайхрах, ад шоо үзэх, бэлгийн болон бусад хэлбэрээр мөлжих зэрэг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах

Хүний эрх салшгүй. Өөрөөр хэлбэл хүний эрх нь хүн бүрт төрөлхөөс заяасан юм. Үүний адилаар хүмүүс сургалтын орчиндоо ч нэгэн адил хүндэтгэл хүлээж байх ёстой. Сурч боловсрох эрх нь хүүхдүүд ялгаатай байх, өөртэйгээ холбоотой асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх зэрэг эрхийг нь хүндэтгэх явдалтай шууд холбоотой гэж үздэг.

Ялгаатай байдлыг хүндэтгэх

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Боловсрол дахь алагчлалын эсрэг Конвенц (1960) нь үндэсний цөөнхийн сурч боловсрох эрхийг хамгаалдаг. Улс орон бүрийн боловсролын талаар баримтлах бодлогоос хамааран, өөрийн төрөлх хэл дээрээ суралцах эрхтэй болохыг зааж өгсөн байдаг. Гэхдээ энэ эрх нь тухайн нийгэмд зонхилж байгаа хэл, соёлоос цөөнхийг тусгаарлах болон нийтлэг стандартаас доод түвшинд сургалтыг зохион байгуулна гэсэн үг биш юм. Соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх ба хөхиүлэн дэмжих тухай конвенц (2005) боловсролын хөтөлбөрийг оролцуулан соёлын ялгаатай байдлыг хүндэтгэхтэй холбогдох үүргүүдийг тусгасан байдаг.

Эх сурвалж: Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1, 2 зүйл; Хүүхдийн эрхийн тухай конвенц, 2, 3, 5, 12, 13, 14, 15, 16, 19, 28, 29 зүйлүүд; Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 18, 19, 27 зүйлүүд;

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 30 дугаар зүйлд хүүхэд өөрийн соёл, шашин, зан үйлийг эрхэмлэх, төрөлх хэлээрээ ярих эрхтэйг онцлон заасан байдаг. Хүний эрхийн олон улсын эрх зүйд эцэг эхчүүд өөрийн хүүхдэд олгох боловсролын талаар шийдвэр гаргах эрхийг хүндэтгэх талаар тусгасан байдаг. Төрийн хувьд ямар нэгэн шашныг сургуульд заах талаар зөвшөөрсөн байдаг. Эцэст нь Хүүхдийн эрхийн тухай конвенцид хүүхэд өөртэйгээ холбоотой байр суурийн зөрүүний талаар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэйг хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ нь боловсрол дахь сонголт хийх бололцоог бүрдүүлэхэд тус дөхөм болно. Гэхдээ соёлын эрх, түүнтэй холбоотой асуудлын талаар бид нэгдүгээр бүлэгт боловсролын талаар хүүхэд, эцэг эх, төрийн үүднээс илүү тодорхой авч үзсэн билээ.

Эдгээр маргаантай асуудлыг шийдвэрлэх хялбархан шийдэл, мөн цорын ганц зөв арга гэж байхгүй биз ээ. Гэхдээ хүүхдийг алагчлахаас хамгаалах, шашин болон соёлд тэднийг хүндэтгэх байдлыг эрхэмлэх, нийгмээс тусгаарлагдах зэрэг боловсрол дахь сул талуудаас сэргийлэх талаар төрд үүрэг хүлээлгэх зэргээр ажиллаж болно. Ялгаатай байдлыг хүндэтгэх, хүний эрхэд суурилсан хандлага нь хүүхэд, гэр бүл, нийгмийн бүлгүүдийг оролцуулах, зөвлөлдөхийг эрхэмлэдэг. Хэрвээ эдгээр үүргүүд биелэхгүй бол сургууль, боловсролын удирдлагууд, төрийн зүгээс тодорхой хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

Оролцох эрхийг хүндэтгэх

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 12 дугаар зүйлд “хүүхэд өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгнө” хэмээн зааж өгсөн байдаг. Оролцооны зарчим нь үзэл бодоо илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх, эвлэлдэн нэгдэх зэрэг бусад эрхээр баталгааждаг. Эдгээр эрх нь боловсролтой шууд холбоотой бөгөөд уг тогтолцоонд хүүхдийн байр суурь чухал ач холбогдолтой юм. Оролцооны эрх нь анги танхим дахь сурган хүмүүжүүлэх харилцаа төдийгүй сургуульд бүхэлд нь улмаар эрхзүй, бодлого боловсруулахад яригдана. Хүүхдийн эрхийн хороо сургуулийн амьдралд хүүхдийн оролцоог аль болох их хангах арга хэмжээ авахыг төр засгийн газарт байнга зөвлөж ирсэн³⁷. Нөгөө талаас хүүхдүүд мөн өөрийн эрхээ эдлэх талаар бусдад нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн зүгээс энэ эрхийг боловсролын тогтолцооны бүх түвшинд дэмжих бодлого, хууль тогтоомжийг боловсруулах шаардлагатай.

³⁷ Hodgkin and Newell, op, cit., p. 159.

Нэгдмэл байдлыг хүндэтгэх

Хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалахын хамт сургуульд сахилга бат тогтоохдоо хүүхдийн эрхэм чанарыг хүндэтгэн хандахыг Конвенцид заасан байдаг. Гэвч сэтгэл санааны хүчирхийлэл буюу гутаан доромжлол дэлхийн олон улс орнуудад нийтлэг хэвээр үлджээ³⁸. Хүүхдийн эрхийн хороо ийм шийтгэл нь хүүхдийн эрхийн зөрчил төдийгүй хүүхдийн нийгмийн нэгдэл, харилцааг таслахад хүргэдэг гэж үздэг. Олонх хүчирхийллийг хүүхэд хүүхдийн эсрэг, хүүхэд багш нарынхаа эсрэг үйлддэг бөгөөд үүнд зан үйл чухал байдаг. Бие болон сэтгэл санааг нь гутаан доромжлох, хүч хэрэглэн харьцах нь зөвхөн хүүхдийн эрхийн хүчирхийлэл төдийгүй сургалтанд маш сөргөөр нөлөөлдөг. Хүүхдүүд ч хүчирхийлэл нь сургууль завсардалтанд хүргэдэг гол хүчин зүйл гэж олонтоо дурдсан байдаг³⁹. Улмаар энэ нь өөртөө итгэх итгэлийг алдагдуулж, хүчирхийлэл бол хэвийн үзэгдэл гэсэн ойлголтыг бий болгодог. Сургуулийн орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэх олон тооны хүчин зүйлүүд байдаг. Тухайлбал:

- Нийгмийн хэм хэмжээ нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх
- Багш нарын боловсрол сул, анги зохион байгуулалт муу, дэг журмыг буруу тогтоодог
- Хэрхэн ангидаа эерэг байдлаар сахилга бат тогтоох, түүний ач холбогдлын талаар мэдлэггүй байх
- Бие махбодийн шийтгэлийн сөрөг үр дагаврыг ойлгохгүй байх
- Хүүхэд хөгжлийн болон суралцах чадварын хувьд ялгаатай болохыг үл ойлгох, сургалтын олон хувилбаруудыг мэдэхгүй байх зэрэг болно.
- Тиймээс шийтгэх болон гутаан доромжлохын бүх хэлбэрийг хориглосон, хүчирхийллийн бус аргаар харилцахыг дэмжсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх ёстой.

“Бүх нийтийн боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлага” бодлогын баримт бичгээс хэсэгчлэн орчуулав.

³⁸ Lansdown, Gerison, Betrayal of Trust: An overview of Save the Children's findings on children's experience of physical and humiliating punishment, child sexual abuse and violence when in conflict with the law, Save the Children, Stockholm, 2006, pp. 33–34.

³⁹ Save the Children, Ending Physical and Humiliating Punishment of Children: Making it happen, International Save the Children Alliance, 2005, p. 40.



НҮБХХ нь мэдлэг, туршлага, нөөцийг холбож, улс орнуудын өөрчлөлтийг олон нийтэд хүргэх замаар илүү сайн сайхан амьдралыг цогцлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮБ-ын дэлхий нийтийн хөгжлийн сүлжээ юм.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай
Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 262902, 262589

Факс: 262786

Цахим шуудан: info@mn-nhrc.org

Цахим хуудас: www.mn-nhrc.org